

Үүсгэн байгуулагч:

Санжаадоржийн

МОЛОР-ЭРДЭНЭ

Ерөнхий эрхлэгч:

Баатарын

ЛХАМСҮРЭН

Редакцийн баг:

Судлаач, орчуулагч:

Эрдэнэболдын АЛТАНШАГАЙ

Нэргүйн БААСАНХҮҮ

Батжаргалын ГАНСҮХ

Баяраагийн ГАНХӨЛӨГ

Саянжамцын МӨНХГЭРЭЛ

Балжиннямын НЯМГЭРЭЛ

Даваасүрэнгийн САНЧИР

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9073010006

Сэтгүүлийн редакцийн хаяг, утас:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, I хороо, 72/2, Замчдын гудамж

Шуудангийн хайрцаг: 44/607 e-mail: philosophy_news@yahoo.com

Харилцах утас: 976-21-242919, 9996-3178, 8813-0099, Факс: 976-21-242919

Сэтгүүлийг дэмжигч:

МОНГОЛ УХААН СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
“ЖОНОН” ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

САНАЛ, БОДОЛ

Философийг Монголд хөгжүүлэх шаардлагатай

Хэрэв философийг Монголд амжилттай хөгжүүлж чадвал дэлхийн университетийн соёл Монголд ирэх боломжтой. Монголчуудын хувьд университетийн тухай ойлголт ердөө л XX зууны дундуур анх орж ирсэн. Гэтэл дэлхийн анхын университетүүд одоогоос 800-гаад жилийн өмнө байгуулагджээ.

Монголын охид хөвгүүд Зөвлөлт Улсын болон Зүүн Европын университетүүдэд суралцаж, анхны мэргэжлийн дипломтой Улаанбаатарт ирж байсан цаг саяхан. Тиймээс университет бүрэн хөгжих цаг хугацаа бага байсан ба бүрэлдэн тогтоох дорвитой ажил хийгдсэнгүй. Үүний нэг шалтгаан бол философийн мэдлэгийг Монголын их сургуульд нэвтрүүлж чадаагүй явдал. Тиймээс Монгол Улсын Их Сургуулийг хөгжүүлэх гэвэл дэлхийн мэдлэгийг философиор дамжуулан үнэнээр оруулж ирэх хэрэгтэй.



Философичид яг л сайэнтистууд шиг асуултаа тавьцааж, мөн түүндээ хариулах гэж оролддог. Лудвиг Виттгэништэйн

Философийн тухай анхны ойлголт

Философи гэсэн мэдлэгийн тухай мэргэжлийн салбар социализмийн эрин үед Марксизм, Ленинизм гэсэн нэрээр зарлагдсанаар жинхэнэ философитой танилцсангүй. Философи нэрийн дор Лениний зохиолууд ноёлсон. Хэдийгээр Ленин Европын орнуудаар явж философийн олон ном уншиж бүтээлээ туурвисан хэдий ч ганцхан түүний номуудыг философи гэвэл гэнэн хэрэг.

Германы болон дэлхийн алдарт философич Марксын номыг орос хэлнээс тойруу замаар орчуулсан. Хэдийгээр герман хэл сурсан зарим хүмүүс орчуулах гэж оролдсон боловч тэд нэгэнт философийн мэргэжлийн хүмүүс биш тул номын амин сүнсийг мэдрээгүйгийн жишээ олон бий. Ганцхан жишээ л гэхэд германаар “Das Sein bestimmt den Bewusstsein” гэсэн ойлголтыг “Ахуй анхдагч, ухамсар хоёрдогч” гэж дэндүү худлаа орчуулжээ. Гэтэл энэ нь үнэн хэрэгтээ “Байгаа чинь л ухааныг чинь тодорхойлно” гэсэн философийн ойлголт.

Энэ ойлголт дотор “байх” ба “ухаан” гэсэн философийн хоёр суурь ухагдахууныг Маркс зориуд хэрэглэсний шалтгаан бол ахуйдаа биш, харин хэрхэн байж чадах чинь гэдгийг чухалчилсан. Ухамсарыг биш ухааныг тодорхойлсон явдал хүний ухаантай байх, эсвэл ухаангүй байхдаа үйлддэг асуудлуудыг хүртэл анхааруулжээ. Худлаа орчуулгын гайгаар “далд ухамсар” гэсэн дэндүү болхи ойлголт газар авсаар.

Философи анхнаасаа л Монголын хөрсөн дээр бууж чадсангүй.

Философи Монголд орж ирж чадаагүйгийн нэг том шалтгаан бол “Монгол хэлний толь бичиг”. Философийн “бодол” ба “сэтгэл” гэсэн хоёр чухал ухагдахууныг хольж солин “Монгол хэлний товч тайлбар толь” номонд Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн болон Я.Цэвэл мэтийн нөхдүүд хэт мэдэмхийрэн бичжээ. Хэрвээ бодлыг сэтгэлтэй хольсон тохиолдолд нэг бол ямар ч мэдрэмжгүй хүмүүс хорвоогоор дүүрч хэн хэнийгээ ч хүндлэхгүй зэрлэгүүд болцгооно. Эсвэл уур хилэн, баяр хөөрөө барьж чадахгүй сэтгэлийн хөдөлгөөнийхөө боол болчихсон хүмүүс улс төрөөр дүүрнэ. Ингэж боддоггүй хүмүүсийн арми гарч ирнэ. Бодохгүй гэдэг ямар их аюултай вэ, энэ тухай монгол хэлний хүмүүс толь бичигтээ залруулан бичих цаг нэгэнт болжээ.

Сэтгэлийн талаар ч гэсэн буруу үгс дүүрэн. Логик сэтгэлгээ гэсэн худлаа ойлголт, сэтгэх гэсэн үгийг бодолтой хольдог, дэндүү худлаа ойлголт зөвхөн арван жилийн сургуульд биш бас нийгэмд гайгаа тарьсаар. Монголчуудын хэл яриа төлөвшөөгүй цагт харилцан яриа хэзээ ч амжилттай болох нөхцөлгүй. Ярилцлага амжилтгүй бол бидний хийсэн үйлдлүүд зөвхөн азаа үзсэн хэрэг болж дэгдэнэ. Одоо тэгээд тэр өдрийн тэнгэр л мэдэж дээ.

Философийн талаархи өнөөдрийн ойлголт

Өнөөдөр амьдралын тухай эсвэл бурхны тухай ганц хоёрхон үг хэлээд л түүнийгээ философи гэх хүмүүс дэндүү олширч, тэр ч бүү хэл дэлхийн философийн мэргэжилтнүүдтэй нүүр тулан ярьж яваагүй хүмүүс философийн тэнхим, эсвэл философийн хүрээлэн байгуулан философийн мэргэжлийн салбарыг гутаасан хэвээр. Зөвхөн өөрийнхөө хагас дутуу номноос юу ч ойлгоогүйгээ залуу үед тулган цээжлүүлж, түүнийгээ шалгалт нэрийдлээр буцааж яриулан дүн тавьдаг философич нэртэй арчаагүй хүмүүс нүгэл хийсээр л. Тэд залуу үеийн амыг хааж айлган сүрдүүлж, оюутны эрхийг доромжилж, наад захын хүний эрх болох хувийн бодлоо хэлэх эрх, чөлөөг хүртэл боогдуулсаар. Үүнийг зогсоож шинээр эхлэх цаг нэгэнт болжээ.

Философийн хоббитой эсвэл сонирхолтой байх нэг хэрэг. Гэтэл түүнийг мэргэжлийн төвшинд суралцах нөгөө хэрэг.

Философи заана гэсэн нэрийдлээр шашин, зурхай, эсвэл хувийн буруу ойлголтоо оюутан залуучуудад дамжуулж, “арга билэг” гэсэн хувийн бүдүүлэг төсөөллөө лекц нэрээр үг эвлүүлэн худлаа зүйл ярьсаар л. Тэд хэзээ ч ямар номноос орчуулснаа хэлэхгүй, бас ямар хэл дээр хэрхэн орчуулснаа ч ил гаргахаас ичицгээнэ. Оюутнуудад гадаад хэл дээрх номын бүлгийг тараан орчуулуулж, түүнийгээ лекц болгон заадаг уламжлал хэвээр.

Өнөөдрийн Монголд нэн тэргүүнд философи хэрэгтэй.

Философийг Монголд оруулж чадсанаар хүмүүс домгийн болон шашны ертөнцүүдээс тусгаарлагдах түүхэн боломж гарна. Домог бол эрт үеийн хүмүүс хоорондоо мэдлэгээ дамжуулан үлдээх арга. Шашны хувьд хүмүүс натурын өмнө хэрхэн өчүүхэн гэдгээ хүлээж, түүнийг биширч, эвийг олохыг хичээж “бурхан” гэж ханджээ. Гэтэл энэ хоёр мэдлэгийн замууд хэдэн зуун жилээр хоцрогдсон. Түүний оронд философи болон сайэнс хоёр хүн төрөлхтөнд мэдлэгийг зааж эхлээд олон зуун жил боллоо шүү дээ.

Домог болон шашны ертөнцөөс салан тусгаарлахын тулд Монгол орны хувьд хоёр зүйлийг урьдчилан хийх зайлшгүй шаардлагатай. Үүнд: нэгдүгээр шаардлага монгол хэл шинэ “Цагаан толгойн үсэг”-тэй болох, хоёрдугаар шаардлага монгол хэлний шинэ “үгийн толь бичиг”-тэй болох. Энэ хоёр шаардлагын дагуу хийж чадвал дэлхийн мэдлэг Монголд ирэх зам шулуудна. Философи жинхэнээр, бас үнэнээр Монголд ирэх боломж улам л ихэснэ. Үнэн зүйл үнэнээрээ, бас мэдлэг мэдлэгээрээ байх тэр л зарчмаар философийг Монгол оронд оруулж ирэх цаг одоо л нээгдлээ. Оройтсон ч гэсэн огт оргүйгээс хамаагүй дээр шүү дээ.

Философи гэж юу вэ?

Философийн асуултууд хамгийн ээдрээтэй, хамгийн их төөрөгдүүлсэн, бас хамгийн их утгатай асуултууд байдаг. Философи ерөөсөө хүний ухааны доторх гүн итгэл үнэмшлүүдийг ганхуулдаг.

Тэгвэл философийн асуултууд гэж ямар асуултууд вэ? Тэдгээр асуултуудын ээдрээг философичид хэрхэн тайлдаг вэ? Үүний тухай ярилцъя.



*“Хүн гэдэг олс бөгөөд тэр олс амьтан ба дээд хүн хоёрыг холбосон.
Нэг үгээр хэлэхэд хавцал дээгүүрх олс...” Фридрих Ницше.*

Хэрхэн философидох вэ?

Зарим хүмүүс философиос татгалздаг. Мэдлэгийн салбарууд дотроос философийг амьдралаас хамгийн хол, тиймээс өдөр тутмын амьдрал ач холбогдолгүй гэнэ. Гэтэл тийм биш. Философи практик амьдралд ач холбогдолтой, бас маш их утгатай.

Хэдийгээр хүмүүс түүнийг ухаардаггүй ч, ямар нэгэн хэмжээгээр философиддог. Зарим хүмүүс өнгөрсний үйлдлүүдийг ирээдүйд баттай хэрэгтэй гэнэ. Энэ бол бас нэг философидолт. Зарим хүмүүс магадтайгаар бурхныг эксистэнц, өөрөөр хэлбэл оршдог гэдэгт үнэмшинэ. Гэтэл зарим хүмүүс бурхан оршдоггүй ч гэсэн үнэмшилтэй гэнэ. Энэ хоёр хоёулаа л философийн асуултууд.

Хэсэг хүмүүс сүнсийг үхэшгүй гэдэгт үнэмшинэ. Нөгөө хэсэг хүмүүс хүнийг зөвхөн материт буюу материаллаг биет гэнэ. Зарим хүмүүс юунд үнэмшдэг вэ гэвэл ямар нэг зүйл хүнээс огт хамааралгүйгээр моралийн талаар зөв эсвэл буруу гэнэ. Тэдний эсрэг хүмүүс зөв эсвэл буруу гэдэг тухайн субъектийн хандлагаас хамаарна гэдэг. Ертөнцийг ч гэсэн реал гэж хүмүүс хэлэхэд зарим хүмүүс “Хүн ертөнцийг ажиглаагүй ч гэсэн ертөнц эксистэнц үү” гэж асууна. Энэ бүгд бас л философийн асуултууд. Хэдийгээр хэн ч дээрх асуултуудыг асуудаг хэдий ч тэр бүр хариулах гэж мэрийдэггүй. Харин мэргэжлийн төвшинд философиддог хүмүүс л хариултын араас насан турш мөшгинө.

Мэдээж өдөр дутмын амьдралд хүмүүс философидно. Философидох ч шаардлагатай. Яагаад гэвэл философи хүмүүсийн амьдралд нөлөөтэй. Жишээлбэл хүн субъектив дураа даган сайн муу моралийн алдаа, жишээлбэл хулгайлах эсвэл хүн алахыг зөвшөөрдөг. Зарим хүн “Бүх зүйл харьцангуй шүү дээ” гэж хэлж магад. Харьцангуй гэдэг бол маш том алдаа. Цаашлаад объектив шалтгаануудаас хамааран хүн алж буй хүнийг буруу гэхийг юу гэж тайлбарлах вэ? Моралийн болон политикийн /улстөрийн/ маргаанууд бас л философийн аспектүүдтэй. Үр хөндөлт, амьтныг хамгаалах, дайнд бэлтгэх, үг хэлэхийг чөлөөлөх гэх мэт бүгд философийн асуулттай давхцана.

Энд ярьж буй асуултуудыг хэзээ ч асуугаагүй, бас тэдгээрийн тухай асуух багаж дутагдсан хүмүүс үнэний тухай, өөрөөр хэлбэл хэр үнэн бэ гэсэн магадыг мэдэх гэж хүсвэл буруу талд зогсож буйгаа анзаарах болов уу.

Хүүхэд мэдэхийг хүссэндээ л ээж ааваасаа “яагаад” гэж асууна. Харин энэ асуулт эцэг, эхийг хүнд байдалд оруулдаг. Тэгвэл философийн асуултууд яг л үүнтэй ижил хүндрүүлдэг асуултууд. Асуултууд өөрөө энгийн, харин хариулт тийм ч хөнгөн шингэн асуудал биш. Философийн асуултыг хүмүүс өдөр тутмын амьдралдаа асуудаггүй. Яагаад гэвэл тэд тэр бүрийг “мэдээжийн шүү” гэнэ.

Философиор бодох заавал цочрооно, гэхдээ төөрөгдүүлэх боломжтой. Философиор бодно гэдэг унахад тосоод авах тор үгүйтэй адил. Хүний баталгаатай гэж үнэмшиж явсан зүйлс гэнэт баталгаагүй болж, магадгүй хүн өөрөө хавцлын хажууд зогсож буйгаа ухаарна. *Гүн хавцал руу харан толгой эргэхтэй адилаар философийн асуултууд дотор муухай оршиулна.*

Тиймээс олон хүн философийн асуултуудаас татгалздаг. Үүнийг бас ойлгох хэрэгтэй. Ихэнхи хүмүүс хаана баталгаатай сэтгэл төрнө вэ, тэндээ л үлдэнэ. Гэтэл рисктэй буюу аймшигтай тулах ашгаа өгнө. Гүн болон өргөн утгатай суурь болсон асуултуудыг тавих үр шимээ тарина. Яагаад сайэнсийн том амжилтууд бүтэлтэй явагдсан бэ гэхээр сайэнтистууд эцсийн хязгаар хүртэл аймшиггүй явсан. Физикч Эйнштэйн, философич Давид Хюмэгийн тухай “Энэ философич л намайг бусдын үнэн гэснүүдийг асуудаг болгосон” гэж хэлжээ.

Зөвхөн сайэнтистууд философийн асуултуудаас ашиг олоогүй бас зарим моралийн ба политикин хөгжлүүд ч гэсэн тодорхой хүмүүсийн асуултуудаар явагдсан. Тэдгээр хүмүүс бусдын “үнэн шүү дээ” гэснийг газар чулуудсан. Чаддаггүй хүмүүс чаддагийнхаа боол болно, эсвэл эмэгтэйчүүд ерөөсөө гал тогооны хүмүүс гэсэн мэдээжийн зүйлүүдийг зарим хүмүүс хөсөр хаяж тэмцсэн. Иймэрхүү моралийн болон политикин дэвшлүүд тодорхой хүмүүсийг бусдын мэдээжийнүүдийг асууж хойш нэг алхан дахин нэг ажиглахыг эрчимжүүлсэн. Ийм л хүмүүс дэлхийд хөгжил авчирсан.

Философчид хэзээнээс эхлэн амьдралаас нэг хойш арагшаа ухарч зогсон асууж бас ажиглаж эхэлсэн бэ?

Философи анх хэрхэн эхлэв?

Одоогоос 2500 гаад жилийн өмнө Энэтхэг, Хятадад, мөн Грект натур, огторгуй, амьдрал болон хүний талаар бодож түүгээрээ мэдэх гэсэн оролдлогууд хийгдсэн тухай философийн номуудад бичжээ.

Энэтхэг болон Хятад оронд бодогчидыг шүтэн биширч, бүр сүүлдээ сүм хийд байгуулагдан догма үүссэн. Ингэж шүүмжилж шалгадаг ажил хийдэг философи зогсож номлож мэдэмхийрдэг хүмүүс олширсон. Тиймээс буддизм, конфуз гэсэн сургаалиуд үлдэж, Азид философи эрчимтэй эхэлсэн хэдий ч хурдан мөхжээ.

Грекчүүдийн бодогчид тийм ч хурдан бууж өгөөгүй, улам цааш асууж шалгаж мэдлэгт ойртож, өнөөдрийн сайэнсийн салбар хөгжих эхлэлийг тавьсан. Сократэс гэх мэт философичид эр зориг гарган хөдөлмөрлөж, өнөөгийн философийн бүхий л мэргэжлийн суурийг тавьцгаажээ.

Философийн эхний үе тийм ч амар байсангүй. Сократэс хор уухаар яллагдаж, Плато академи байгуулсан хэдий ч үргэлжийн довтолгоон дор философидсон. Аристотел өөрийн философийн сургууль болох “Лицей” байгуулсан хэдий ч сүүлдээ ад үзэгдэн Афин хотоос дайжсан. Энэ бүгд юуны гэрч вэ гэхээр мэдлэгтэй хүн тийм ч амархан үнэнийг гараасаа тавидаггүйн гэрч.

Ингээд Философи Грект өрнөж, дараагаар Ромд хөгжиж цааш Франц, Англи мөн Германд дээд хэмжээнд хөгжин оргил үеийг эзэлсэн. Дэлхийн мэдлэг, физик, хими, биологи, психологи гэх мэт олон салбар төрөн гарч хүн төрөлхтөн ардчилал, төр, сурган хүмүүжил болон боловсролын тусламжтайгаар соён гэгээрэлд хүрсэн. Хэдийгээр цөөхөн орон энэ боломжийг эдэлсэн хэдий ч Грек, Латин, Англи, Герман болон Франц хэлээр дамжин дэлхийн сонгодог философчидтой танилцах боломжтой болжээ.



Хэрвээ хүн философиор бодож эхэллээ гэвэл өдөр тутмын амьдралаас арагшаа зогсож, мэдээжийн гэсэн зүйлсэд эргэлзэж, дээрээс бүгдийг харан ажиглахыг хэлнэ.

Монголд дэлхийн сонгодог философчидын бүтээлтэй шууд танилцах боломж гарсангүй. Англи, Франц болон Герман гэх мэт философчидийн өлгий нутгуудад философийн мэргэжлээр хүмүүс сурсангүй, бас философийн зэрэгтэй хүмүүс ч бэлтгэгдсэнгүй. Зөвхөн өнөөдөр л энэ боломж биелэгдэх цаг ирлээ.

Философи ба шашин


Философийн ихэнхи асуултуудыг шашныхан тавьдаг. Шашинд ч гэсэн универзийн эхлэл буюу анхдагч бас яагаад зүйлс заавал байдаг, харин юу ч биш байдаггүй вэ гэсэн асуултуудад хариулахыг оролдоно. Зарим шашин хэлэхдээ бурхан универзийг бүтээсэн гэнэ. Зарим Монголын шашны хүмүүсийн орчуулсан номуудад хүртэл ертөнцийн эзний тухай бичиж, бүр эцэстээ ертөнцийг эзэнжүүлдэг тал бас ажиглагдана. Олон шашин “сүнс” гэсэн үг хэрэглэнэ. Тэд сүнсийг хүн бүрт бий гэнэ. Нэгэнт асуултууд заримдаа давхацдаг тул зарим философичид бас теологчоор ажилласан.

Хэдийгээр философийн болон шашны асуултууд давхацдаг хэдий ч олон ялгаа бий. Тэр ялгаанууд юу вэ? Нэг том ялгаа бол “ухамсар” гэсэн ухагдахуунд өгөх утга. Ухамсар гэдэг хязгаартай. Философийн олон асуултууд ухамсраар шийдэгдэхгүй. Философи хүнийг хэрхэн зоригжуулдаг вэ гэхээр “чадахынхаа хирээр ухамсарлаарай” гэдэг.

Шашин хэдийгээр хүний ухамсрын тухай ярьдаг ч, тэд өөр замаар үнэн лүү ойртдог. Жишээлбэл маань мэгзэм, гартаа эрхи эргүүлэх, судар чангаар уншиж цээжлэх, библи уншиж, хүмүүсийг нэгэн дуугаар дуулуулах гэх мэтэд утга өгнө. Зарим шашныхан ухамсараас татгалзана. Философичид аливаа үнэн ба түүний баталгаануудыг шалгадаг онцлогтой. Философичид өөрсдийнхөө баталгааг рационалиар зөвтгөдөг. Ингэж илүү сайн зөвтгөснөөр жинхэнэ үнэнийг зөвтгөнө.

Философиор бодох

Философичид бодох үүрэгтэй ба бодох төрлөөр ажиллана. Тэдний бодох төрөл тийм ч онцгой бас тусдаа бодох биш. Эрүүл ойлгоцтой хүний өдөр дутам боддог бодолтой адил. Яагаад машин ассангүй вэ, энэ хүн үнэнийг хэлэв үү, нэг газраас нөгөө газар луу хэрхэн хурдан очих вэ гэх мэтээр хүн боддог. Мэдээж өдөр тутмын асуултуудыг хариулахад заавал ухамсар хэрэггүй. Гэхдээ ухамсар өдөр тутмын асуултуудын заримыг тодруулж чадна. Хүмүүс эцсийн хариултыг олж чадсангүй гэсэн үед философичид хариултыг хангалтгүй гэнэ. Тиймээс философичдын бодол ямар ч шийдэлгүй үед ашигтай. Яагаад философиор бодох хэрэгтэй вэ гэдгийн шалтгаан энэ жишээгээр хариултыг одоохондоо л зөвшөөрснөөр нээлттэй орхиж буйгаар харагддаг.



“Ухамсар унтах үед аймшиг төрнө” гэсэн зураг хүмүүсийг айдасынхаа, гэмтүүдийнхээ, бас мухар сүсгийнхээ эсрэг соён гэгээрэх тухай сэрэмжлүүлдэг.

Философи ба сайэнс

Философийн зарим асуултуудад сайэнтистууд хариулж чадах хэмжээнд хүртэл асууна. Жишээлбэл “Яагаад заавал нэг “юу” байх ёстой вэ?”, “Хаанаас би виртуэл рэалитид биш вэ гэдгийг мэдэх вэ?”, “Моралийн зөв ба буруу гэж юуг хэлэх вэ?” “Хүмүүс үнэхээр хүссэнээрээ чөлөөтэй эсэх?”

Сайэнтистууд дээрхи асуултнуудад хариулахгүй. Яагаад гэвэл тэдэнд урьдчилал хэрэгтэй. Жишээлбэл дараах асуулт. “Хүн өөрийгөө иллуз ертөнц дотор баригдсан уу эсвэл үгүй эсэхийг хэрхэн мэдэх вэ?”. Холливуудын “Matrix” нэртэй фильмыг үзэхэд дараах асуултуудыг тавьдаг. Тэнд хүнийг үнэхээрийн биш ертөнцөд амьдарч буй гэж төсөөлдөг. Тэнд хүмүүс төрөхдөө л залгууранд залгаатай төрдөг. Яагаад гэвэл хүний нервийн системийг хиймэлээр залж, харин цаанаа бол хүнийг компьютерийн системтэй холбосноор харуулдаг. Эмпирийн сайэнсаар хүний зөвхөн таван мэдрэлийн эрхтэнүүдээр л рэалититэй холбогдсон ба түүнээс ондоогоор үзэх үзлүүдийн танихуйг татгалздаг. Тиймээс тэд хүмүүсийг хэрэг дээрээ иллузид амьдрах хохирогчид уу гэдгийг тодруулж чадахгүй.

Дараагийн жишээний асуулт бол “Яагаад заавал нэг юу байх ёстой вэ?”. Сайэнтистууд универзийн эхлэл “анхны тэсрэлт” гэсэн ухагдахуунаар постулацладаг ба тэр тэсрэлт өнөөдрөөс ойролцоогоор 13 миллиард жилийн өмнө тохиосон. Энэ анхны учрал зөвхөн “материйг” болон “энергийг” бүтээгээгүй, бас “хугацаа” ба “орон” хоёрыг бүтээсэн. Үүний судалгаа хүмүүст юу заавал байдаг, харин байдаггүй биш гэсэн асуултуудад хариулахгүй. Тэд ямар асуултуудад хариулах вэ гэхээр яагаад энэ анхны тэсрэлт учрав, бас энэ тэсрэлт учрахгүй байх боломжтой юу гэсэн асуултуудад хариулна. Гэтэл хариу өнөөдрийг хүртэл гараагүй.

Сайэнтистууд “ухагдахуун” ба “утга” хоёрыг эхлээд тодруулаагүй тул дээрх асуултанд хариулж чадаагүй. Тиймээс мэдлэг үйлдвэрлэхэд ухагдахуун ба утга шаардлагатай. Хэрэв хүмүүсийн хүсэл чөлөөтэй эсэхийн тухай асуувал түрүүлээд чөлөөтэй хүсэл гэж юу гэсэн утгатай гэдгийг тогтохоос гадна, бас энэ ухагдахууны агуулгыг зайлшгүй тодруулах шаардлагатай. Сайэнсийн фактуудаар энэ асуултыг хариулж чадлаа гэхэд “чөлөө” гэж юу гэсэн утгатай вэ гэдгийг мэдэхгүй бол хариулах боломжгүй. Ухагдахуун ба утга хоёр хоёулаа философийн гол даалгаврууд.

Янз янзын метод

Хэдийгээр философичид асуултанд хариулахын тулд ухамсарыг хэрэглэдэг ч асуултанд хэрхэн ойртох аргууд янз янз. Жишээлбэл асуултын зөв хариултыг олж чадахгүй гэхэд зарим хариултуудыг буруу гэж чадах ба буруугийн магадыг тодорхойлно. Үүнээс бас ондоогоор ч хариултыг хайдаг. Радикалаар философичид юу гэж хэлдэг вэ

гэхээр асуулт буруу тавигдсан гэнэ. Жишээлбэл “Яагаад юу бий, харин юу ч биш үгүй вэ?” гэсэн асуултанд дараахи байдлаар хариулна.

Хэдийгээр энэ асуултыг шууд хариулах гэж оролдох боломжтой ч, асуулт цаанаа ямар нэг учиргүй. Хэрвээ хүн “юу ч биш” гэвэл тэнд юу ч байхгүй. Нэг өрөөнд юу ч байхгүй гэвэл тэнд үнэхээр юу ч байхгүй. Гэтэл юу ч биш эсвэл, юу ч байхгүй цаашилбал “хоосон” гэсэн хэллэг цаанаа радикал. Яагаад гэвэл бид юу ч биш, эсвэл хоосны тухай ярина гэвэл тэнд хугацаа ч үгүй, бас орон ч үгүй. Гэтэл юу ч үгүй хоосны тухай асуух ямар учир бий вэ? Үүнийг төсөөлөх ч ямар нэг учиргүй тул түүнийг асуух ч учиргүй.

Бодох чадвар

Философиор бодох хэрхэн ашигтай тухай олон жишээний нэг бол практикаар философидох нь хүнийг бодох чадвартай бас бэлтгэлтэй болгоно. Үнэний тухай бодоход тусална. Философийн бодлыг бусад салбаруудад ашиглах боломжтой ба хэзээ ч хуучирдаггүй, өөрөөр хэлбэл хоцрогдохгүй. Логикийн алдаануудыг олоход эсвэл аргуудтаа тод илтгэхэд философи хэрэгтэй. Өнөөдөр хөгжилтэй орнуудын олон компаниуд философийн мэргэжилтэй залуусыг хөдөлмөрт дуудаж хамтран ажилладаг.

Философийн бэлтгэл, логиктой болон критиктэй бодлууд практикт үргэлж хэрэглэгдэнэ. Жишээлбэл хүмүүсийг улс төрийнхний залинд бас сэргэлэнд автагдуулахгүй, эмнэлгийг оролсон сүм хийдийн худлаа эмчлэгч нараас хамгаална, худалдаа наймаачдаас болгоомжлуулна, бөө нараас, бас зурхайч нараас, цаашилбал толгой эргүүлж тархи угаах гэсэн хүмүүсээс хол байхад тустай. Хүмүүс хувийн дүгнэлт гаргахад, мөн магадгүйд үнэмшихэд философийн болон критиктэй бодол автагдуулахгүй.

Сургуулийн насныханд, мөн залуучуудад философийн бодол интелгенцтэй болгохоос гадна бас эмоционалын болон социалийн интелгенцтэй болгоно. Хэн багаасаа философитой уулзана вэ, тэр хүн амьдралын турш түүгээр тэжээгдэнэ.

Зүгээ олох

Философийг мэдэж бас хэрэглэж чадсанаар хүмүүс цааш философийн салбаруудтай танилцаж тэдгээрийг ойлгоно. Сонгодог философичдын бүтээлүүдийг уншиж эхэлнэ гэдэг уншиж сурахын нэг баталгаа. Яагаад гэвэл философийн хэл бодлын хэл учраас сонингийн дассан хэлнээс эрс ялгаатай. Эцсийн эцэст философи хүмүүсийг “өөрөө бодож” сурахад туслана. Философчид юу хэлснийг уншиж, түүнийг давтахдаа биш харин яг тэдний бодлоор бодож сурах хэрэгтэй.

Сократас хор ууж үхэх ял авсны дараа “Шалгаагүй амьдралаар амьдрах хэрэггүй” гэж хэлсний цаад учир юу вэ гэхээр философидохгүйгээр амьдрах амьдрал биш гэжээ. **Аливаа нийгэмд философи үгүй гэвэл тэр нийгмийг эрүүл гэж хэлэх бэрхтэй.** Хэрвээ нийгмийн чухал сэдвүүдийн тухай критиктэйгээр бодох боломжгүй гэвэл тийм нийгэм зогсонги, баригдсан хэлбэртэй байна.




Хэрвээ хүн философиор бодож эхэлбэл нийтийн урсгалын эсрэг алхахтай адил. Ингэснээр хүмүүсийн мэдээжийн эсвэл баттай гэсэн ойлголтуудыг асууж шалгах ба заримыг магадтайгаар цуцална.

Санжаадоржийн МОЛОР-ЭРДЭНЭ

ФИЛОСОФИЙН ШИНЭ СЭДВҮҮД

Хүний оюуны тухай философи ба түүний сэргэн мандалт.

Хүний “оюуны” буюу “майндын” тухай философийн оргил үеийг Рене Декарт, Иммануел Кант, Давид Хюмэ гэсэн философчидтой холбон тайлбарладаг. Тэдний бичиж үлдээсэн номыг судалсан орчин үеийн судлаачдын дүгнэлт дээрхи философичдын сургаалиуд хэрхэн ул суурьтай болохыг баталдаг. Үүний хажуугаар Фридрих Хегелийн “майндын феноменологи” ном ч бас хүний оюуны тухай л өргөн фронтоор нухацтай өгүүлдэг.



Өнөөдөр философийн салбарт сонгодог асуултуудын хажуугаар оюуны тухай асуулт нилээд эрчимтэй, бас бага ч үгүй маргаантайгаар яригдаж, түүнчлэн судалгааны ажлуудын үр дүнг хэлэлцэж эхэллээ. Оюуны философийн хамгийн чухал салбар бол хүний “ухаан”. Ухаан судлал өнөөдөр эрчимтэй хөгжиж буйн шалтгаан тархины сайэнсийн амжилт мөн.

Хүн хэрхэн “ухаантай” байгаа, мөн заримдаа яагаад “ухаангүй” мэт хэрэг тарьдаг тухай философчид судалгаа хийж, эцэстээ философийн бие даасан салбарууд үүссэн. Тэр байтугай “ухаангүй”-гийн тухай сургаал явсаар “психологи” гэдэг мэргэжлийн салбар болон хувирчээ. Энэ хувьсгалын эцэг бол Сигмунд Фройд. Фройдын асуусан олон асуултын нэг болох “Яагаад хүн өөрийн хяналтаас гадуур үйлдлүүд хийдэг?”, “Хүн өөрөө ухаараагүй байхад ухаан шаардлагагүй, өөрөөр хэлбэл “ухаангүй” хэсэг олон зүйлийг бие даагаад хийчихээд байгаа”-г мэдэх гэсэн хүсэл түүнээс бүхий л амьдралын турш хариултаа нэхсэн. Үүнд хариулах гэж л Фройд бүх амьдралаа зориулжээ.

Фройдын психологийн судалгаа

Фройдын ухаангүйн тухай сургаалыг “далд ухамсар” гэж ташаа орчуулжээ. Хүн ухаан алдаж унаад ухаангүй байх, мөн түүний дараа ухаан орж ухаантай байх зэрэг үнэндээ далд ухамсартай ямар ч хамаагүй. Ухамсар бол философийн эртний салбар.

Фройд хүн өөрийн ухаангүй юм хийчихдэг, тэр ч байтугай хүн ямар нэг зүйлээс айх, эсвэл эгдүүцэх нь зөвхөн нэг удаагийнх биш, хэвшил болчихсон байдаг тухай судалсан. Энэ бүгдийг хүн өөрөө ч олигтой ухаарч өөрийгөө барьж чадалгүйгээр амьдралын тодорхой ситуацуудад ухаангүй хөдөлж ил гарч идэвхит амьдралд саад учруулан хүнийг хэрхэн идэвхгүй байдалд оруулдаг тухай судалжээ. Хаана ухаангүйгийн анхдагч үүсвэр байна вэ, мөн юунаас шалтгаалж хүн сэтгэлийн доголдолтой болсныг анх

удаагаа эрчимтэй, нэг ёсондоо хүний сэтгэлийг уудлан нээх “археологчийн” ажлыг мэргэжлийн төвшинд хүртэл Фройд гүйцэтгэсэн.

Хүмүүсийн сэтгэлийн доголдлууд бүр хүүхэд байхаас л эх үүсвэртэй байдгийг Фройд олж тогтоосон. Жишээлбэл эрэгтэй хүүхэд багадаа загнуулж занчуулснаар сэтгэлд сэв сууж хожмын амьралдаа шантрах, эсвэл гаж үйлдэл хийхийн эх үүсвэр болдог бол, харин охин хүүхэд багадаа хавьтах гэж дайрсан эрэгтэй хүнээс хэт айсанаас болж эмэгтэй хүн болж хөгжих хөгжилд нь хэрхэн сөргөөр нөлөөлдөг болохыг психологийн салбар хүний ухаанд нуугдаж буй “нуугдмал”, дарагдаж буй “дарагдмал” ухаангүй гэж нэрлэдэг.

Фройдын гол зорилго дарагдаж буй, мөн хүнийг үргэлж дарамттай байлгадаг ухаангүйд хэрхэн ямар замаар ойртох арга хайх байсан ба үүнийгээ “зүүдний тайлбар” гэжээ. Хүний зүүдийг сонсож, тэндээс хүний сэтгэлийн доголдолын үүрийг олж засвар залруулга хийх нь психоанализийн гол зарчим ба үүнийг Фройд анх онолын хувьд бодож амьдралд нэвтрүүлжээ.

Хүн маргахдаа амархан, бусдад буруу өгөхдөө хурдан, сэтгэл өвчтэй байх, үргэлжийн гашуудах зэрэг явдал бол хүүхэд наснаас эхлэлтэй гэж Фройд номондоо бичжээ. Бага балчираас эцэг нь хэт их мэдэмхийрч заах, эсвэл ээж нь хувийн хэрэгт нь оролцож хорих, мөн ихэд эрхлүүлэх зэрэг бүгд л эцэстээ эр хүн болж чадахгүй, бас эмэгтэй хүн болж төлөвшихгүй, бие насанд хүрсэн ч оюуны чадвар бүрэлдэхгүй, өөрийгөө удирдах чадваргүй байдгийн гайнуудаар илэрдэг ажээ.

Хүн дурлалд автагдах, эсвэл үхэл рүү татагдах гэх мэт сэтгэлийн хөдлөлүүдийн цаана тэр л бие болон сэтгэлийн холбоос болох “юманд автагдах” үүр байдаг. Бүр хүүхэд байхдаа л хүн хүсэлтэй, фантаазтай, хайр дурлалын мэдрэмжтэй, айдаг, агресив, сэтгэлээр унадаг. Зөвхөн энэ бүгдийг эцэг эх болон сурган хүмүүжүүлэгчид хэр бага наснаас зөрчилдүүлж сургаж, зөв ойлгуулж, бие даан шийдэж сургахад л хэргийн учир оршино.

Фройдын гаргасан нэг сонирхолтой онол бол “би биш”, “би” ба “дээд би”. Би биш уурладаг, зугтаадаг рефлексгүй бас инстинктгүй. Эдгээр ухаангүйд хамаарна, яагаад гэвэл хүн өөрөө ухаарахгүй үйлддэг. Би болохоор рисковийг тооцоолно, эргэн санана, моралийн зарчимтай. Би биш ба би хоёрын дунд аймтгай сэтгэл, жишээлбэл нэг л удаа цахилгаанаас айсан хэдий ч айсан хэвээр, мөн гараа угаагаад салахгүй өөрийгөө албадах, архи ууж өөрийн эрхгүй донтох зэрэг. Дээд би жинхэнэ интеллигенттэй бөгөөд ойролцоогоор мэргэн гэсэн утгатай.

Тархи судлаачдын ололтууд

Орчин үед дэлхийн хөгжилтэй орнуудын тархи судлаачид Фройдын гаргасан “ухаангүйн” тухай онолыг баталгаажуулж, түүний хүний ухаангүйн тухай салбарт байгуулсан онцгой чадварыг магтдаг.

Хүний ухааныг судалж, түүндээ тулгуурлан хүний санамжийн тухай баталгаатай болох гэсэн судлаачдын ажил хөдөлмөр өнөөдөр эрчимтэй явагдаж байна. Яагаад гэвэл орчин үед мэдлэгийн цар хүрээ ихсэж, информациин үйлдвэрлэл асар хурдацтай хөгжиж буй эрин цагт хүний санамжийн багтаамж тэлж маргалтыг багасгах боломжийн тухай ихэд анхаарах болсон.

Хүн мартана гэдэг сурснаа мартана гэсэн ойлголт ба энэ хүний мэдлэгтэй шууд холбоотой. Хэрэгтэй зүйлсээ мартсанаас болж толгойноосоо гадагш гарган алдана гэдэг тухайн хувь хүнд ямар их хор хохиролтойг судлаачид ухамсарлаж, хүний төлөө ухамсарт үйл ажиллагааг эрчимтэй явуулж байна. ***Хүний ухамсар бол ил тод, харин хүний ухаан бол далд нууц.***

Биологийн салбарт ДНА-гийн тухай судлан нээлт хийсэн Нобелийн шагналт Английн биологич Францис Крик сүүлдээ тархины салбарт ажиллаж, хүний ухааныг судалж эхэлсэн ба дэлхийн судлаачид хүний ухааны далд нууцыг ил гарган мэдэж авах гэж ямар их хичээж байгаагийн гэрч. Крикийн судалгааны чиглэл хүн “ухаан алдах” ба

“ухаан орох” үед хэрхэн мэдрэлийн системүүд ажиллаж, хүн өөрөө өөрийгөө мэдэрч эхэллээ гэх, тодруулж хэлэхэд “надад мэдээ орлоо” гэхийг юу гэж ойлгох тухай судалгаа хийсэн байдаг.

Орчин үеийн тархи судлаачдын гол барьж буй чиглэл хүний оюун гэдэг тусдаа биш харин тархины невронуудаас хамааралтай. Тиймээс материас салган судлах боломжгүй гэсэн чиглэл. Өөрөөр хэлбэл хүний бодол, төсөөлөл, санамж, мэдрэл, сэтгэл, мэдрэмж гэх мэтийг ямар нэг байдлаар багажны тусламжтайгаар хэмжиж тогтоох боломж бий гэсэн таамаглал тархи судлаачдын үндсэн байр суурь. Хүн ухаантай байна гэдэг тархи судлаачдын хувьд дараахи дөрвөн шинжийг агуулах ажээ. Үүнд: мэдрэлийн эрхтнүүдийн мэдээнүүд мэдрэгдэн хүн орчин тойрныхоо үйл явцын утгыг бас эрч хүчийг мэдрэх, ментал төлөв ба ажиллагаа, бодол, төсөөлөл, санах, эмоц, шаардах, мөн төлөвлөх, хүсэх, үйлдэл гүйцээх.

Энд нэрлэсэн бүхий л шинжүүд магадгүй хүний тархины аль нэг хэсэгт гэмтэл үүсэхэд явагдах боломжгүй, өөрөөр хэлбэл ажиллах боломжгүй болох гэнэ. Орчин үед тархи судлаачид хүний ухаан бол зөвхөн хэдэн невронуудын үйлдлүүд гэсэн тайлбар. Тэр невронуудын үйлдсэн үйлдлүүдийг хүмүүс мэдрэл, когиниц, сэтгэл эсвэл хөдөлгөөн гэж нэрлэдэг ажээ. Тархин дотор ухаан байна гэдэг зөвхөн макрофизик, биохими ба физиологийн механизмуудын үйлдлийн үр дагавар гэнэ. Тиймээс ухаан ба бие гэсэн хоёр зүйл байхгүй гэж эхэллээ. Зөвхөн бие гэж л бий, тэр биеийн үйлдлүүдийг ухаан гэж нэрлэжээ гэсэн дүгнэлтэнд тархи судлаачид хүрчээ. Өөрөөр хэлбэл хүмүүс ухаантай эсвэл ухаалаг гээд буй зөвхөн л тархин доторхи невронуудын гялс манас хийхийг л хэлээд буй. Тэгэхээр хүн тархиныхаа юу хийхийг л хүлээгээд суухаас биш өөрөө нэг их ухаараад шийдэж байгаа биш ажээ гэсэн энгийн дүгнэлтэнд ч хүрч болохоор. Гэхдээ л энэ бүгд өнөөдөр огт тодорхойгүй бөгөөд судлаачдын анхаарлыг улам бүр татсаар.

Оюуны философийн судалгааны салбарууд

Философичдын тайлбарлаж байгаагаар эмпирийн салбаруудтай ажилладаг философийн чиглэлүүд анхнаасаа тайван байгаагүй. Натурын философи явсаар физик болсон, рационал психологи явсаар эмпирийн психологи болсон. Өнөөдөр оюуны философи невроны мөн когницийн сайэнсаар солигдож, хүний ухааны талаар шинэ ойлголт гарч ирэх тун ойртжээ.

Философийн олон зуун жилийн асуултууд, методтой бодлын аргууд мөн ухагдахуунуудын цэгцлэл, өөрөөр хэлбэл нарийвчлал зэрэг эцсийн эцэст шинэ салбар үүсэж, оюуны сайэнс болон ухааны тухай шинэ онолууд бүтээхэд тус болох ирээдүйтэй. Гэхдээ л хэзээ нэг цагт философийн үүрэг тэгсгээд дуусах ажээ. Мэдээж тэр дуусах хугацааг ойролцоогоор 100 гаруй жил болов уу гэж таамаглаж байна. Яагаад гэвэл тархийг бүрэн дүүрэн судалж ухаан гэж байхгүй, бас оюун гэж байхгүй гэсэн баталгаанд хүртэл асар их судалгааны ажил хүлээж буй. Энэ ажлыг Галилей хэрхэн огторгуйн тухай таамаглал гаргаж, түүнээс хойш хэдий хугацааны дараа физик өнөөдрийн асар өндөр хөгжлийн төвшинд хүрсэнтэй мэргэжилтнүүд зүйрлэж байна.

Натурын бүх юмс ердөө л адилхан атом молекулуудын цуглуулгаас тогтохыг физикчид илрүүлж чадсан. Тэгвэл тархийг ч бас судлаад ердөө л хэдхэн энгийн механизмаар хүсэл, сэтгэл, төсөөлөл ажилладаг, тэд хоорондоо ялгагдах онцын зүйлгүй гэсэн дүгнэлтэнд тархи судлаачид хүрэх гэсэн цаад учиртай. Өөрөөр хэлбэл хүний ухаан, санаа, мэдрэмж бүгд л тархины үйлдлүүд бөгөөд маш энгийн юу ч нууц биш гайхах юмгүй хялбархан гэсэн л ойлголтонд хүрэх. Нэгэнт л ойрын 100 жилд дээрхи судалгааны ажлын үр дүн гарахгүй тул философичдын хийх ажил чамлалтгүй их ажээ.

Өнөөгийн философичдын нэг асуулт бол хүн хэрхэн “ухаантай мэдэрч”, бас “ухааралгүй мэдэрч” байгаа хоёрын ялгааг тодруулах. Одоогоор философийн мэргэжлийн гурван дэд салбарт хүний ухааны талаар судалгаа явуулж байна. Нэгдүгээрт, шинж чанарын дуализм, хоёрдугаарт, интеракционы дуализм, гуравдугаарт, идентитэтийн теори.

Шинж чанарын дуализм гэсэн ойлголт ментал процесууд заавал неврунууд оролцолгүйгээр биш бие даан явагддаг гэнэ. Жишээлбэл хүн өвдөнө, эсвэл өвдөж байна гэж буй неврунууд өвдөх гэдгийг үйлдэж буй биш, харин хүний өвдөхийн тухай хэлэх, булчин шөрмөсний ажиллагаа, мөн хүн өвдөх тухай мартаагүй байх гэх мэт процесууд ажээ.

Интеракционы дуализмын үед менталын ба невруны процесууд харилцан хамааралтай ажиллана. Жишээлбэл хүний шийдэл үйлдлийн шалтгаан, мөн мэдрэмжүүд мэдрэмжийг хэрхэн илэрхийлж буй шалтгаанууд. Өөрөөр хэлбэл хүн гараа өргөх нь хүний өөрийн ухаарч хүссэн хүсэл байхаас биш тархи судлаачдын хэлсэнээр гараа өргөхөөс өмнө тэртэй тэргүй неврунуудаа гялс хийлгээд гарыг хүний өөрийн хүслээс түрүүлээд өргүүлчихдэг гэсэн онолын зөрчил.

Идентитэтийн теори хүний ухааны үйлдэл ба хүний нервийн идэвхижилт хоёрыг яг ижлээр буюу идентитэтлэж тайлбарлаж болох уу гэсэн асуулт. Өөрөөр хэлбэл хоёр процес яг ижил явагдах уу гэдгийг тодруулах. Жишээлбэл хүн арван жилийн сургуульд хамт сурч байсан найзтайгаа уулзалдахгүй байсаар 20 жилийн дараа уулзана гэвэл мөн байна гэж таних ба яагаад гэвэл ижил байсан тул. Ухааны хувьд гэвэл хүн өвдсөн өвдөлтөө, өөрийн санаагаа мөн өөрийн хүслээ өөрөө л шууд ухаарна. Үүнтэй төстэй хүний тархины неврунууд хэрхэн тэр үйл явцыг батлах вэ гэсэн л асуулт гарч ирсэн.

Оюуны философийн нэг чухал салбар бол хүний ухааны бүтэц ба үйлдэл. Хүний ухаанд хэрхэн айх, өнгөнүүд ялгах, өвдөх гэх мэт үүсдэг вэ л гэсэн асуулт. Яагаад гэвэл тархин дотор л энэ бүгд явагдах тул ямар үйл явц цаашилбал тархины хаана бас юу удирдаад айлгаад байна вэ гэсэн л асуулт. Айгаад байгаагийн эхлэл болох тэр л цэгийг тархин дотор олоод засчихвал хүн айгаад байна гэсэн хийсвэр зүйлгүй л болно гэсэн ойлголтыг өнөөдөр эрчимтэй ярилцах боллоо.

Эцсийн эцэст философийн сонгодог асуултууд анхнаасаа л нэгд ухаан гэж байдаг уу, өөрөөр хэлбэл ухаан тэгээд реал уу, хоёрт хүн гэдэг чинь бие даасан субъект шүү гэсэн статус, мөн гуравт хүн өөрөө чөлөөтэй хүссэн шүү гэсэн асуултууд байсан ба өнөөдөр ч байсан хэвээр.

Хүн субъект шүү гэсэн асуултанд хариулах гэж нео-Платочууд эртнээс л ярилцсан ба харин хүн чөлөөтэй хүсч буй хүслийн тухай бүр Аристотел ярьж байжээ. Гэтэл хүн ухаантай, өөрөөр хэлбэл ухаан гэж реал зүйл шүү гэсэн асуулт орчин үед тархи судлалаас болж асуудлын төвд тавигдсан. Ухааны тухай асуултанд хариулах боломжийг өнөөдөр тархи судлаачдын зүгээс өгөх судалгааны үр дүнгүүд харуулж буй. Харин хүн субъект гэсэн, мөн чөлөөтэй хүссэн тухай эмпирийн судалгаанууд хийгдээгүй тул цаашид зөвхөн л философийн асуулт хэвээрээ үлдэнэ. Ерөөсөө философийн асуултууд хариулагдаж дуусахаараа цаашаа мэдлэгийн бие даасан сайэнсийн салбар болон хөгжиж, баталгаатай мэдлэгүүдийг үйлдвэрлэдэг. Харин хариулагдаж чадаагүй асуултууд цааш хариултаа хүлээсээр философийн салбартаа хоцордог. 2500 жилийн өмнөөс л эхлэн хоцорсон асуулт бүрийг хариулах гэж философийн мэргэжлийн салбар уйгагүй ажилласан хэвээр...

Санжаадоржийн МОЛОР-ЭРДЭНЭ

Хүн өөрийгөө таних бас ухамсартайгаар бодох чадвартай.

Хераклит.

Бүх юм өнгөрдөг гэдгийг үргэлж санацгаа. Тэгвэл хүн жаргалд баярлахгүй
бас зовлонд гутрахгүй.

Сократэс.



АНТРОПОЛОГИЙН /ХҮН СУДЛАЛЫН/ ФИЛОСОФИ



Хелмут Плеснер

Х.Плеснер 1892 онд Германы Висбаден хотод эмч хүний гэр бүлд төрсөн. 1910 онд эмчийн мэргэжилд, түүний дараа философийн мэргэжилд сурсан. Германы Гөэтингэн хотын их сургуульд 1952-1961 он хүртэл философийн профессороор ажилласан Плеснер философийн антропологиин салбарыг үндэслэгчдийн нэг юм.

Плеснерийн эксцентрик позицййн тухай

Плеснерийн антропологи хоёр асуултыг асуудаг.

1. Амьд феноменоос амьгүй феномен ямар ялгаатай?
2. Амьд феноменууд хэрхэн зохион байгуулалтанд ордог?

Эхний асуултын хариулт хилчлэл органик биш биетээс ялгаатайгаар организмууд өөрийнхөө ахуйд хамааралтай ба хэрхэн хилчлэгдсэн түүгээрээ зохицуулагдана. Ургамал ба амьтан хоорондоо хил тогтоодог төрөлтөнгүүд. Хоёрдугаар асуултын хариулт позиц буюу монголоор ойролцоогоор байршил гэсэн ухагдахуунаар Плеснер гурван төрлийн амьд организмуудыг ялгасан. Үүнд:

1. Ургамал
2. Амьтан
3. Хүн

Түүнийхээр бол энэ гурав хэрхэн байршлагдсан түүгээрээ ялгарна. Ургамал нээлттэй зохион байгуулалттай ба нэгдсэн эрхтэнгүүд, амьтан центрээр буюу төвөөс удирдагдсан байдлаар амьдардаг тул төв цэгтэй. Харин хүний амьдралын зохион байгуулалт эксцентр зохион байгуулалттай. Энэ юу гэсэн үг вэ гэхээр амьдралыг хүн хэдийд ч ойлгох буюу өөртөө тусгах чадвартай. Энэ ойлгох чадварыг “өөрийн ухаан” гэж Плеснер нэрлэсэн. Гэхдээ тэр энэ ухагдахууныг философийн “оюуны” салбараас тайлбарлаагүй, харин биологит үндэслэн тайлбарласан. Ингэхдээ тэр хүнийг нэгд биетэй, хоёрт биетэй гэж хуваасан.

Антропологиян хуулиуд

Эксцентр байршлын тухай судалгаандаа зориулан Плеснер “Натурын урлалын тухай хууль”, “Хамаатай, хамааралгүйгийн тухай хууль”, “Утопын хууль” гэсэн гурван антропологиян хуулийг гаргасан. Энэ гурван ялгаагаар хүн өөрөө ертөнцийг дотроо гурав хуваадаг. Гадаад ертөнц, дотоод ертөнц, хамтын ертөнц. Эдгээр нь соёл, түүх, нийгэм гэсэн ойлголтуудыг илэрхийлдэг.

Эндээс Плеснер дараагийн антропологиян хуулийг гарагасан ба тэр бол улсын төрийн тухай. Плеснер биологийн сууринаас социологийн асуудлуудаа гарган тавьсан. Түүний антропологиян бодол нь хүн гэсэн түүхэн бус ухагдахууныг тойрсон явцуурал байгаагүй. Тиймээс хууль гэсэн ухагдахуун юу хэлсэн бэ гэхээр хүн биеэсээ шалтгаалан ертөнцөд өөрийгөө нээж өгөх шаардлага гарч ертөнцийг урлах, түүхчлэх болон нийгэмчлэн байгуулсан.

Плеснер хүнийг оюуны болон натурын сайэнсын гэсэн 2 салбарт тусгайлан судалж буйг буруутгасан. Яагаад гэвэл хүн нэгдүгээрт бие гэсэн физик гэсэн экзистэнцээр байдаг ба хоёрдугаарт хүн тэр биеэ агуулдаг учир өөрийнхөө оюуны төрөл болон бие гэсэн зүйлтэй гэдгээ мэддэг. Үүнийг Плеснер шүүмжилж тусад нь биш, хамтатган судалж хоорондоо хамааралтай гэдгийг анхааруулсан.

Плеснерийн социологийн тухай бүтээл

“Хамтын амьдралын хилүүд” номын тухай. Плеснер энэ номоо 1924 онд бичсэн ба хүмүүсийн хамтын буюу социаль амьдралын янз бүрийн хэлбэрийн тухай асуултанд хариулсан. Хүмүүсийн хамтын амьдрал доторх тэнцүү бус байдлыг болон хоорондын хилүүдийг арилгах гэсэн оролдлогууд хүмүүст сөргөөр нөлөөлнө. Яагаад гэвэл хүн өөрөө бусдаас хиллэх, зайлах болон ганцаарчлах зайлшгүй шаардлагатай. Тиймээс Плеснер хамтын амьдралыг сул дорой үйлдэл гэж хэлээд тэдэнд заавал удирдагч хэрэгтэй, тэр удирдагч тодорхой мэдэлтэй болдог тул тэнцүү бус байдал үүсдэг гэжээ. Ингээд Ницшэгийн хэлсэн аморалийн шаардлага гардаг.

Плеснерийн хувьд хэн хүчтэй вэ гэхээр хамтын амьдралыг зөвшөөрсөн хүмүүс ба харин хэн сулхан хүмүүс вэ гэвэл хамтын амьдралаас зугатааж үгүйсгэсэн хүмүүс ажээ. Гэхдээ Плеснер нийгмийн тодорхой харьцаанууд болох социализм ба капитализмыг чухалчлаагүй, харин хамтын амьдралын абстракт идеалийг чухалчилсан.

Хамтын амьдралыг хоёр замаар эсэргүүцдэг. Эзэрхийлэх гэсэн морал ба Ницшэгийн хувьд хувь хүнийг бүгдийн дээгүүр тавих, нөгөөтэйгүүр нийгмийн морал ба энд Марксын хэлснээр ард түмнийг хувь хүний дээгүүр тавих.

Хэдийгээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон шинэ технологиуд хүмүүст аюул авч ирдэг ч Плеснер техникийн дэвшлийг хүмүүст экзистэнцийнхээ цар хүрээг нэмэгдүүлэх боломж олгодог тул зөвтгөсөн. Гэхдээ техникийн эрин үед түүнийг зөвхөн дагах биш харин ухаарах хэрэгтэй. Мэдээж энэ ухаарал цөөн тооны хүмүүст оноогдоно. Тиймээс нийт хүмүүс ухаарч чадахгүй тэр чигээрээ үлдэнэ.

Техник ба нийгэм хоёр салшгүй холбоотой. Хэрэв техник гэсэн ухагдахууныг өргөтгөвөл багаж болон хэрэгслүүдтэй харьцах олон хэлбэрүүд гарч ирдэг.

Хамтын амьдралын боломжууд

Хөдөлмөрчин ба иргэн хоёрын хооронд шинэ холбоо үүссэн. Хөдөлмөрчин материаллаг дутагдалтай тул нийгмийг шүүмжилж эвсэн нэгдэнэ. Харин иргэн Этикийн зөрчилд орсон бөгөөд, техникийн хөгжил хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилсөн. Ингэж эзэрийлэх морал ба хамтын морал иргэд ба хөдөлмөрчдийг нэгтгэсэн. Эндээс нийгмийн хоёр төрөл гарч ирсэн. Нэгдүгээрт, цусан төрөл, хоёрдугаарт бодит төрөл.

Цусан төрөл

Цусан төрөл заавал биологийн биш, харин сэтгэлийн хөдөлгөөнөөр хамтрах. Хэрэв энэ хамтын амьдрал хамаатан садангаас бүрдээгүй бол билэгдлийн чанартай учир энэ сэтгэлийн хөдөлгөөнөөр хамтран амьдрах идэвхитэй амьдралын хэлбэрийг үүсгэх ба үүнийг хайр гэнэ. Яагаад гэвэл хайр абстракт, бүхэл бүтэн зүйлд чиглээгүй тул зөвхөн нэгэн зүйлээр л илэрхийлэгдэнэ. Хүчтэй удирдагчид хүмүүсийн хайр чиглэх жишээ бий. Гэхдээ энэ хайр хугацааны хувьд хязгаартай төлөв бөгөөд энэ төлөв жишээлбэл хямралын үед, дайны үед идэвхижэнэ. Энэ төлөвийг хугацааны хувьд үргэлжийн болгох гэвэл хүмүүсийн хамтын хайр хэзээ ч тогтмол байх боломжгүйгийн эсрэг зогсдог. Эндээс л хамтын амьдралын дээд хязгаарын тухай ойлголт гарч ирсэн.

Бодит төрөл

Бодит төрөл үнэтүүдээр болон нормуудаар тодорхойлогддог. Тэр рационал болон интеллигэнц учир соён гэгээрлийн үеэс гаралтай. Тэдний багаж дайн биш харин үнэмшүүлэх. Тэднийг холбосон холбоо хайр биш харин ухамсар. Тэдний теори универсал хүчинтэй ба харин тэдний практик идейгээ биелүүлэхийн төлөө ажил.

Тэд бүхий л хүмүүс адилхан сайнаар амьдрах тухай үнэмшлээ орчин үеийн сайэнс авсан бөгөөд бодит төрөл болон сайэнс хоёр хоорондоо хамааралтай. Гэхдээ өдөр тутмын амьдралд абстракт идейг биелүүлэх боломж бага. Яагаад гэвэл амьдралын үнэн түүнээс ялгаатай. Амьдрал гэдэг богино, хүн өөрийнхөөрөө л санаачилдаг. Хүн бүрийн чөлөөт хугацаа болон уламжлалт заншлаар хязгаарлагдсан. Ингэж өдөр тутмын амьдрал нийгмийн доод хязгаарын тухай ойлголтыг гаргадаг.

Энд бид хамтын амьдралын хоёр сөрөг хил хязгааруудын тухай ярьлаа. Үүнд: олон нийтийг үгүйсгэх боломжгүй, хүн бүрийн амьдрал болон хүмүүсийн оюун хоёрыг адилтгах боломжгүй.

Дүгнэлт

“Хамтын амьдралын хил хязгаар” номондоо Плеснер хамтын амьдралыг хамтралжуулах биш харин нийгэмчлэх тухай ярьсан. Үүний тулд Плеснер антропологийн философийг хүчтэй гаргаж ирсэн. Хүмүүсийн хамтын амьдралыг үргэлжийн эв найрамдалтай байх боломжгүй гэж хэлсэн. Энэ төлөв байдал богинохон хугацаанд үргэлжилнэ. Жишээлбэл дайны үед хэн дээрх төлөвийг удаан хугацаагаар үргэлжлэхийг шаардана вэ, тэр хүн хүмүүсийн сэтгэлийг хүчлэхтэй адил. Яагаад гэвэл бие хүн хөгжихийн тулд бусдаас болон ойр орчныхоо хүмүүсээс зай авах шаардлагатай. Тиймээс Плеснерийн хэлснээр хүмүүсийн хооронд хил хязгаар зайлшгүй шаардлагатай. Ингэж чадсан хүмүүс нийгэмд бие даан амьдрах чадвартай болно.

Тиймээс олон нийтийн дунд биеэ авч явна гэдэг нийгмийн тоглоомын дүрмүүдийг сайн эзэмшиж, бусадтай найрсагаар болон эелдэгээр харьцах чухал гэдгийг Плеснер номондоо өгүүлжээ.

ОНТОЛОГ /БАЙХ-ЫН ТУХАЙ/ ФИЛОСОФИЙН САЛБАР



Мартин Хэйдэггэр /Германы философич, 1889-1976/

“БАЙХ БА ХУГАЦАА” номын орчуулга

Удиртгал

- “Байх” ухагдахууны учрын тухай асуултын экспозиц
- “Байх”-ын тухай асуултыг чухалчлах, структурлах ба урьдуурчлах

Нэг. “Байх”-ын тухай асуултыг давтаж буйн чухалчлал

Хэдийгээр бидний энэ хугацааг “Метафизик”-г дахин тиймлэх гэж дэвшилтэт гэж тооцдог хэдий ч дурьдагдаж буй асуулт өнөө үед мартагджээ. Гэтэл энэхүү хөндөгдсөн асуулт бол энгийн биш. Энэ асуулт Плато бас Аристотелийн судалгааны ажлыг өрнүүлсэн хэдий ч тэндээс эхлэн жинхэнэ шинжилгээнийхээ сэдвийн хувьд чимээгүй болсон. Энэ хоёр философичийн бүтээсэн бүтээлүүд хэдийгээр дарагдаж, засварлагдсан ч Хегелийн “Логик” хүртэл тэссэн. Тухайн хугацаанд гүн бодлыг феноменуудын дээд хэмжээнд хүргэж чадсан ч хэдийнээ тривиалчлагджээ.

Зөвхөн энэ биш. “Байх”-ыг интерпретацлах гэсэн Грекчүүдийн санаачлагын хөрсөн дээр нэгэн догма бүрдсэн. Тэр Байх-ын учрын тухай асуултыг зөвхөн илүү гээд зогсоогүй мөн тэр асуултыг орхисныг санцласан. Тэдний хэлсэнээр Байх генерал бас хоосон ухагдахуун. Ингэснээрээ тодорхойлох гэсэн оролдлого бүрийг эсэргүүцсэн. Хэт генерал, тодорхойлохын аргагүй ухагдахуунуудыг тодорхойлох шаардлагагүй гэжээ.

Хүн бүр тэдгээрийг үргэлж хэрэглэнэ. Хүн бүр бас юу гэснийг ойлгоно. Ингэснээрээ антикийн философийг үргэлж тайван биш болгож, үргэлж хөдөлгөдөг тэр нууцыг нарны гэрэл туссан мэт тодорхой ойлгомжтой болгосон. Түүгээр ч барахгүй тэр тухай асуусан хүн бүр методын алдаа хийж буй мэтээр ад үзэгдэх болжээ.

Байх-ын тухай шинжилгээ эхлэхийн өмнө түүний тухай бүхий л ялгаварлалыг авч үзэх боломжгүй. Яагаад гэвэл Байх-ын тухай асуултыг үргэлж шинээр асуух шаардлагагүй гэдгийг ургуулж бас арчилдаг. Үүний үндэс антикийн үеийн онтологид оршдог. Байх-ын тухай асуултын хариултыг бас тодруулгыг интерпретацласан хүрэлцээтэй гэдэг тул бид

энд ялгаварлалын дискуссийг нэг талын тодруулга болтол явуулах ёстой. Гэтэл дараахи гурван тодруулга бий. Үүнд:

Нэг. Байх генэрал ухагдахуун. Байх-ын тухай ойлголт бүхий л юманд хамт. Бүхий л “Байгаа”-нуудыг¹ бас хамруулдаг. Харин Байх-ын генэралчлал бүлгийн генэралчилал биш. Байх, байгаа-гийн регионуудын дээд хэсгийг хиллэсэн биш. Хэрэв тэдгээр бүлгээрээ, мөн төрлөөрөө илэрхийлэгдсэн гэвэл Байх-ын генэралчилал бүхий л бүлэгчилсэн генэралчлалыг давдаг. Тэгэхээр Байх дундад зууны онтологийн нэрлэгээгээр трансценденс. Бүлэг ухагдахууны эсрэг генэралчлалын трансцендентал генэралын нэгж бүлэглэлийн ухагдахууны олон гэдгийн эсрэгээр Аристотел аналогийн нэгж гэдгээр танигдсан. Энэ нээлтээр Аристотел Платогын онтологийн асуултаас хамааран Байх-ын тухай пролбемыг шинэ сууринд аваачсан. Категорын хамаарлуудын харанхуйд зөвхөн Аристотел гэрэл оруулаагүй. Дундад зууны онтологийн урсгалууд жишээлбэл Томистын бас Скотистын сургуулиуд энэ асуудлын тухай дискусс хийжээ. Харин олигтой тодруулгад хүрээгүй байна. Хэдийгээр Хегел Байх-ыг тодорхойгүй, хамааралгүй гэж тодорхойлсон “Логик” номондоо категорийн экспликациудыг цааш тодорхойлсон ч түүний харааны антикийн онтологитой нэгэн чиглэлд. Ингэснээрээ Хегел Аристотелийн тавьсан проблемуудыг категоруудын олноудын эсрэг гараасаа алдсан. Хэрвээ Байх-ыг ерөнхий ухагдахуун гэвэл энэ түүнийг тов тодорхой цааш судлах ямарч шаардлагагүй гэсэн үг биш. Байх-ын тухай ухагдахуун илүүтэй хамгийн харанхуй.

Хоёр. Байх-ын ухагдахуун тодорхойлогдохгүй. Үүнийг дээд хэмжээгээр генэралчилсанаас гарган авсан. Энэ ч зөв. Байх хэрэг дээрээ Байгаа-нууд гэдгээр ухагдахуунчлагдахгүй. Байх түүнд Байгаа-нуудыг хамааруулснаараа тодорхой болохгүй. Байх-ыг тодорхойлоход дээд ухагдахуунаас гаргалгаа хийх боломжгүй. Мөн доод ухагдахуунуудаар дүрслэх боломжгүй. Эндээс тэгэхээр Байх проблемгүй гэсэн үг үү? Үгүй. Эндээс юу гэж хэлэх вэ гэхээр Байх, Байгаа-нууд биш. Тэгэхээр Байгаа-нуудыг тодорхой хязгаар доторх зөвтгөсөн байгаа-нуудыг тодорхойлох аргууд байх-д хэрэглэх боломжгүй. Традиционал логикийн дефенецион антикийн логикт фундаменттэй. Байх-ын тодорхойлогдохгүй, өөрөө түүний учрын тухай асуултыг холдуулах биш, харин шууд шаардана.

Гурав. Байх өөрөө ойлгомжтой ухагдахуун. Бүхий л танихуйдад, хэллэгүүдэд, байгаа-нуудын төрхүүдэд, өөрөө өөртөө гаргах төрхүүд дотор Байх-ыг хэрэглэдэг. Ингэж илэрхийлсэн илэрхийллүүд ойлгомжтой мэт. Жишээлбэл: бүгд л ойлгодог. Тэнгэр хөх Байна-, би баяртай Байна гэх мэт Байх-ууд. Ерөөсөө энэ л дунд зэргийн ойлгомжууд ойлгомжгүйг бүтээдэг. Төрх бүрт мөн Байгаа-нуудад байх-ыг байгаанууд гэж буйд априори таавар өгөгдсөн. Бид хэдийнэ Байх-ын ойлголтуудын дотор амьдарч буй мөн Байх-ын учир харанхуйгаар бүрхэгжсэн гэх мэт суурь зайлшгүйг баталж буй бөгөөд Байх-ын учрын асуултыг давтах гэж.

Өөрөө ойлгомжтой гэсэн үйл ажиллагаа философийн суурь ухагдахуунуудынхаа хувьд мөн Байх ухагдахууныг ажиглахад эргэлзээтэй процесс гэмээр. Хэрэв өөртөө мэдээжийн нийтийн ухамсрын /Кант/ нууц ялгаварлал, мөн аналитикийн илэрхийлсэн сэдэв болж, мөн түүгээрээ үлдэх ёстой гэвэл /мөн аналитикийн философичдын хийдэг хөдөлмөр/ сэдвүүд болсон үед мөн цаашид байх ёстой үед.

Ингэж урьдчилан дурьдсан, юуг тодруулсан бэ гэвэл Байх-ын тухай асуултанд зөвхөн хариулт дутагдсан биш, мөн тэр асуулт өөрөө харанхуй, мөн чиг үгүй. Байх-ын тухай асуултыг давтсанаараа юуг хэлсэн бэ гэвэл дээрхи асуултыг тавилтаа хамгийн түрүүнд хангалттай боловсруулах.

¹ “Байгаа” гэсэн ухагдахуунаар Хайдэггэр номын чухал ухагдахууныг тэмдэглэсэн.

Хоёр. Байх-ын тухай асуултын формал структур

Байх-ын учрын тухай асуулт тавигдах ёстой. Хэрэв энэ асуулт Байгаа-д зогсохгүй бүр фундаментал асуулт гэвэл түүнийг тохирох хэмжээгээр транспарэнт² судлах шаардлагатай. Тэгэхээр юуг дурьдах хэрэгтэй вэ гэвэл энэ асуулт мөн үү гэдгийг тэгснээрээ Байх-ын асуултыг ил тод харагдахаар болгох.

Асуулт бүр эрэл. Харин эрэл бүр өмнөх эрлээс гаралтай. Асуулт гэж Байх ба ийм Байх-ыг таньсан эрэл. Таньсан эрэл судалгаа болох боломжтой. Өөрөөр хэлбэл юуг асуусныгаа чөлөөтэйгээр тодорхойлох. Асууна гэдэг асуугдаж буйгаа асуух. Бүхий л асуух түүнээс асуух. Асуухад асуугдсанаас гадна бас асуугдагч хамаарна. Судлагдсан энэ юу гэсэн үг вэ гэхээр спицифик теоричилсон асуултанд асуугдсан тодорхойлогдох ёстой ба тэгснээрээ ухагдахуун болох ёстой. Асуугдсан дотор реал³ интэндиртэ асуугдагч өгөгдөх ба тэгснээрээ асуулт зорилгодоо хүрнэ. Асуулт өөрөө байгаа-гийн төрх. Өөрөөр хэлбэл асуугчийн ба Байх-ын характер. Нэгэн асуулт “зөвхөн ингэж л асуусан” эсвэл эксплицит асуулт тавих хоёрын аль нэг. Эдгээрийн онцлог уундаа вэ гэвэл асуулт өөрөө энэ бүхий л асуултын характеруудын нэрлэх үед өөрөө транспарэнт болдог.

Байх-ын учрын тухай асуулт тавигдах ёстой. Тэгснээрээ бид энд яригдсан структурын моментууд доторх Байх-ын асуултыг дурьдах зайлшгүйгийн өмнө хүрч ирнэ.

Эрэл гэдгийнхээ хувьд асуулт өмнө асуусны дамжуургыг шаардана. Тэгэхээр Байх-ын учир бидэнд эзэмших боломж хэрэгтэй. Юу гэсэн үг вэ гэхээр бид үргэлжийн л Байх-ын ойлголт дотор хөдөлдөг. Эндээс л Байх-ын учрын тухай асуулт урган гарч мөн түүний ухагдахууны тэндэнци урган гардаг. Байх юуг хэлж буйг бид мэдэхгүй. Харин бид Байх гэж юу вэ гэсэн асуулт тавьж буйгаараа Байх гэж юу гэснийг ойлгосон шиг өөрснийгөө үздэг. Байх-ыг ямар утгатай гэдгийг ухагдахууны хувьд фикс буюу яглаж чадаагүй тул. Бид хаанаас эхлэх, хэрхэн онох горизонтоо ч таниагүй. Энэ дундаж хэмжээний мөн таасан Байх-ын тухай ойлголт факт.

Байх-ын тухай энэ ойлголт хэт их хэлбэлзэлтэй, бүдэг бас энгийн үгээр хэлэхэд боломжгүй ч энэ Байх-ын тухай ойлголтын тодорхой биш өөрөө позитив феномени. Түүнийг тодруулах шаардлагатай. Тэгсэн хэдий ч Байх-ын учрыг шинжлэхийн тулд эндээс эхлэхгүй. Дундаж хэмжээний Байх-ын ойлголтын интэрпретацн хэдийд гарч ирэх вэ гэхээр Байх-ын ухагдахууныг зураглан гаргасны дараа. Ухагдахууны гэгээнээс мөн түүнийг эксплицит ойлголтоос бүдэг бас гэгээн болоогүй Байх-ын ойлголтууд зайлшгүй гарах ёстой.

Дундаж хэмжээний, таамагласан Байх-ын ойлголт бидэнд уламжлагдсан Байх-ын тухай теоринуудаар бас санаануудаар өгөгдсөн хэдий ч энэ теоринуудын эх булаг нийтлэг ойлголтынхоо хувьд нууцлагдсан хэвээр. Байх-ын тухай асуусан асуултанд буй эрлүүд ерөөс танихгүй биш хэдийгээр барьцгүй ч гэсэн.

Боловсруулах гэж буй асуултын асуугдсан Байх мөн Байгаа-нуудын Байгаа-нууд л гэж тодорхойлогдсон ба хэдийгээр олон дахин дурьдагдсан ч ойлгомжтой. Байгаа-гийн Байх, өөрөө Байгаа-нууд биш. Байх-ын пролбемыг ойлгоход анхны философийн алхам юу вэ гэхээр нэгэн түүхийн тухай яриа биш шүү. Үүнийг юу гэж ойлгох вэ гэхээр Байгаа-гийн Байгаа-г бусад Байгаа-нуудад аваачиж тавих биш өөрөөр хэлбэл Байх боломжийн Байгаа-нууд биш. Байх асуугдсан гэдгийнхээ хувьд өөрийн гэсэн ажиллагааг шаарддаг ба энэ Байгаа-нуудыг илрүүлэхээс ерөөс ялгаатай. Үүгээрээ асуугдагч ба Байх-ын учир өөрийн гэсэн ухагдахууныг нэхэмжилдэг. Энэ Байгаа-нууд өөрийнхөө утгыг тодорхойлсон ухагдахуунуудаас дээгүүр ойлголт.

Хэдийд Байх асуугдсаныг илэрхийлэх, мөн Байгаа-гийн Байх-ыг илэрхийлсэн үед Байх-ын асуултын асуугдагч Байгаа-нууд өөрөө. Энэ түүний Байх-руу чиглэн асуугдсан.

² Транспарэнт ойролцоогоор нэвтэрхий ба нэвт харагдах.

³ Реал-угийн, бодит, үнэхээрийн байдал

Тэнд сенсаацын физиологийн тодорхойлолт үгүй, мөн ерөнхийдөө тэнд илүү физиологийн психологи үгүй ба автоном, яагаад гэвэл физиологийн тохиолдол биологийн болон психийн хуулиудыг дагадаг. Элементар физикийн функцийн идентифайэнт-ын хамгийн лавтай методыг дагалдах болзол удаан хугацааны турш бодогдсон ба биеийн субструктуртай хатуу биш супериор функцээс тэд ялгардаг. Гэсэн ч хаагдмал анализ давхардсан функцийг хоёр төрлийг дэлгэдэг. Элементар учрал хэдийн санаа орсон байдаг ба субординац операцуудыг сублимацлах ба ашигласнаар илүү хүчинтэй адаптац эсвэл экзистенцийн илүү интэграцчилагдсан шинжийг функц авчрах болно. Эсрэгээрээ сенсе-эксперенс бол витал процесс. Психологи болон физиологи илүү гүнзгий биш хоёр паралэл сайэнс, гэвч бэхэйвэрийн хоёр интерпретац бий.

Эхнийх абстракт, хоёр дахь нь конкрет. Бүх сайэнс түгээмэл сенсээс зээлдэг мөн тэдний хөгжилд саад болдог реалист прижудайсаас салахыг физиологич хичээсэн. Модэрн физиологид “элементар” гэсэн термийн санаа өөрчлөгдсөн ба философийг зарладаг. Сайнтист гадаад ертөнцийн идейг шалгах ёстой ба ингэснээр фактууд түргэн мөн мессеж трансмицлэх бие гэдгээр орхисон. Юу сенсэд ойлгогдсон тэр бол сенсибл. Юуг бид цэвэр бодсон гэвэл рефлекс хоёр дахь сайэнсийн рефлекс хүртэл тодорхойгүй гэдгийг бодсон. Бид сэтгэх, харах, сонсохоо мэднэ гэдэгтээ итгэдэг ба одоо үгнүүд проблемыг нэмэгдүүлдэг. Бид юмсыг дахин тодорхойлохын тулд тэднийг дамжуулж эксперенсийг урьдаг.

Сенсаацын уламжлалт ойлголт рефлектээс төрсөн концепц биш, гэвч иймээс илүү тодорхой биш ба түүний оригинал сурвалжаас алсад хөдөлгөсөн, ертөнцийн төлөөллийн сүүлчийн элемент объект руу чиглэсэн бодлын сүүлийн продукт. Субъективигийн объектив сайэнсийг үндэслэснээр мэдлэгийн продуктыг хууль захирдагийг нээснээр сайэнсийн мэдлэгийн циркл хаагдсан ба актуал перцепцийг үүнд сууриладгийг дахин реконституцлахыг оролдсон, тэдний физик химийн шинжүүдээр үндэслэгдсэн стимул физикийн систем шиг хүний биеийн зураг хөгжсөн, энэ ерөнхийдөө объект руу зүтгэдэг зайлшгүй сайэнс.

Гэвч зайлшгүйгийн чармайлт бүтэлгүйтэх ёстой. Гешталт теори юуг тодорхой хийсэн гэвэл гол хэв боломжтой хийх хэмжээнд зөвхөн эффектлэснийг тэд хэрэглэсэн, хэсгийн хувьд хэсгийг захирахгүй сенсор талбайн гаднах болзлууд тэр бүх нээлтийн бид анхных нь, хэрэв бид объектийн шалгалтанд эргэж ирвэл. Ойлгомжийн ямар нэг төрлийн замыг нээх ба физик математикийн анализуудын инструментуудыг сайн мэдэхээс бүрэн зугтах үр дагавартай, тэдгээр нь урт биш физикийн хувирамтгайнууд, болзлын биологийн

санаа шиг организм доторх структур хувирамтгайгаас хамаарна. Бид перцептуал руу эргэж ирвэл, субъективитигийн зөвхөн шинжийг бүтээхдээ л сайэнс амжилт олохыг ойлгоно. Юмсын тухай сенсаацын интерпретациал, эксперенс санаагаар дүүргэгдсэн хэвийг үзүүлдэг. Зөвхөн сайэнсийн универсыг сенсе хийдэг, энэ хүч феноменал унивэрсээс категорууд руу.

Тэнцүү эсвэл тэнцүү биш байх ёстой хоёр ижил реал персивлэгдсэн шугамыг шаарддаг ба персивлэгдсэн кристал слайдын тоогоороо тодорхойлогдох ёстой. Түүний контекстээр дүрсжинэ, мөн өөрчлөгдөнө. Миуллэр-Лайэрсин иллюзийн шугамын нэгийг зогсоовол тэнцүү ба бусад гаднах тэнцүү биш болно. Изолацлагдсан объектив шугамууд ба ижил шугамын фигур өгөгдсөн. Энэ идентифицлэх боломжтой хоёр функц зөвхөн аналитик перцепцээр идентифицлэх боломжтой болдог ба натураар биш. Ижил замд персивлэгдсэн хоосон зайнуудыг персивлэх бүтэхгүй биш. Түүний хажуу талыг тооцноор байх үгүйгээс ердийн шейп байх шиг кристалыг магадгүй би харах болон хүрэхээрээ танина.

Сенсаацын теори мэдлэгийн реал сэдвүүдээс илүү идеалийг, абсолют болон цэврийг, бүх салаа утгатайгаас объектийг цэвэрлэж өгдөг, тогтоогдсон квалитэтээс гадна бүх мэдлэгийг ихэсгэдэг, товчхондоо энэ ухааны суперструктуртай саяхныг хүртэл нийцтэй хөгжсөн. Хаана сенсаацын идэй буй вэ гэвэл ойролцоогоор танигдах. Үүний өмнө инстинктийн төлөвлөгөө тэр имиж, тэдгээр генэрац бүрийн уламжлалыг сэргээх эсвэл энгийн мөрөөдөл, тэдгээр анхны байрлалдаа генуин перцепцтэй тэнцүү тулах цэгтэйгээр үзүүлсэн ба аажимдаа шүүмжилсэн хөдөлмөрөөр, үнэн, үзүүлэх ба илэрхий перцепц бол фантаазаас ялгагдсан.

Перцепц гэсэн үг примитив функцээс илүү чиглэлийг заадаг. Ялгаатай зайнд объектийн үзэгдэх хэмжээний униформитийг эсвэл объектийн ондоо ондоо гэрлүүдтэй өнгийг насанд хүрэгчдээс илүү хүүхэд мэддэг. Хүүхдээс насанд хүрэгч сенсаацын теоритой илүү зохицдог ба хүүхдийн хөгжөөгүй стэтээс насанд хүрэгчийн хөгжсөн локал стимултай перцепц илүү хатуу хүлэгдсэн. Илүү тодорхой ба илүү тодрох түүний зангилаатай нэттэй энэ адил. Примитив бодол зөвхөн примитив хүмүүсийн хариу үйлдэл, тэдгээрийн шийдвэр мөн социологичдын перцептуал эксперенсийн фондтай релацласан интерпритацуудаар ойлгогдсон аргаар зурагдсан. Энэ заримдаа түүний контекстийн персивлэгдсэн объектын баримт ба түүний вискосити, заримдаа позитив шалтгаан үгүйгийн пресенс, идентифицлэх боломжтой термүүд ба дистинкт, шийдэж болох цэгцтэй болохоос бүхэл тооны ба хугацааны, зайн болоход саад болдог. Энэ бол при-объектив реалм хэрэв бид сенсе-эксперенсийг ойлгохыг хүсвэл өөрсдөө судлах хэрэгтэй.

Даваасүрэнгийн САНЧИР

Жаргалын хаалга гэдэг дотогшоо
онгойдоггүй тул хүн жаргалыг авахын тулд
гүйж орох биш, харин жаргалын хаалга өөрөө гадагшаа
онгойдог тул хүн юу ч хийх хэрэггүй.

Киеркегаард



“ЗӨВ”-ИЙН ФИЛОСОФИ



Жон Роулс /Америкийн политикийн философич, 1921-2002/

АНУ-ын эрхийн философич Жон Роулс 1921 онд төрсөн. Роулсын гол бүтээл бол 1971 онд хэвлэгдсэн “Theory of Justice” /“Зүй”-гийн онол/ ном юм. Номын гол зорилго тэнцүү байдлын онол дээр тулгуурлаж, утилитаризмын онолын эсрэг үндэслэгээ дэвшүүлсэн.

Ном гурван дэвтэртэй бөгөөд эхний дэвтэрт “Зүй-гийн теори”, хоёрдугаар дэвтэрт “Зүй-гийн институцууд”, гуравдугаар дэвтэрт “Зүй-гийн зорилгын талаар” гардаг. Нэгдүгээр дэвтэр “Зүй-г фейрнес гэх”, “Зүй-гийн суурь горимууд”, “ Үндсэн нөхцөл” гэсэн гурван бүлэгтэй. Хоёрдугаар дэвтэр “Бүгдэд адилхан фрийдом”, “Тэнцүү хуваарьлалт”, “Үүрэг ба даалгавар” гэсэн гурван бүлэгтэй. Харин гуравдугаар дэвтэр “Сайныг ухамсартай гэх”, “Зүй-гийн мэдрэмж”, “Зүй-тэйгийн сайнууд” гэсэн гурван бүлэгтэй. Роулсын “Зүй”-гийн онол бол Ж.Локкэ, И.Кант, Ж.Руссо нарын нийгмийн гэрээтэй адилаар нийгмийн онол болж чадсан чухал бүтээл билээ.

“Зүй”-гийн теори

Бүлэг 1: “Зүй”-г фейрнес гэх.

Удиртгал болгон энэ бүлэгт “зүй”-гийн тухай бодлынхоо бүдүүвчлэлийг хийсэн ба энэ бодлоо цааш үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Энэ дүрслэл хөнгөн, мөн дараа дараагийн аргуудад цаашдын замыг бэлтгэнэ. Зарим давтагдсан хоорондын давхацлууд цаашид тохиолдохыг арилгах боломжгүй. Би “зүй”-гийн тухай болон түүний ролийг тодорхойлохдоо хамтран амьдрах социалаар эхэлсэн ба “зүй”-гийн тухай гол ойлголтуудад богинохон анализ хийсэн. Өөрөөр хэлбэл нийгмийн суурь структурт. Үүний дараа гол бодлуудаа гаргаж тавьсан ба эдгээр “зүй”-г фейрнес гэх “зүй”-гийн тухай теори. Энэ бол өнөө үеийн нийгмийн гэрээний төсөөллийг генэралчлах, мөн абстракцын өндөр төвшинд хүргэнэ.

Нийгмийн холбоо хэлхээсийг мөн аргументацуудыг боловсруулахдаа хязгаарласан анхны ситуацаар орлуулсан ба мөн “зүй”-гийн тухай суурь асуултуудтай анхлан тохиролцоход тааруулсан гэгээрүүлэх зорилготойгоор харьцуулан тавихдаа би “зүй”-гийн тухай классик утилитаризмын болон институцийн төсөөллүүдийг авч үзсэн. Тэдгээрийн хоорондын ялгаануудыг ажиглаж мөн “зүй”-г фейрнес гэсэн цааш удирдах бодол “зүй”-гийн тухай теорыг хөгжүүлэх, тэгснээрээ харах харцанд хэрэгцээтэй алтернативыг зураглах ба энэ бол философийн традицад удаан хугацаагаар ноёлож ирсэн.

“Зүй”-гийн роль

“Зүй” бодлын систем дотор үнэн эрдэм бийтэй адил социалын институц доторх анхны эрдэм. Хэдийгээр элегант ч гэсэн мөн хэмнэлттэй методуудыг хэрэглэсэн ч теори өөрчлөгдөх, мөн хаягдах зайлшгүй хэрэг гардаг. Хэрэв тэр үнэн биш гэвэл үүнтэй адил хуулиуд болон институцууд хэдийгээр сайн ажилладаг ч, хоорондоо таарч тохирдог ч түүнийг “зүй”-тэй биш бол өөрчлөх, мөн хүчингүй болгох шаардлагатай. Хүн бүрийн “зүй”-тэй гэсэн барил нийт нийгмийн тусын тулд гэсэн үүднээс ч устгагдах ёсгүй. Тиймээс хувь хүний “зүй” олонхийн сайны төлөө хүний фрийдом алдагдахыг зөвшөөрдөггүй. “Зүй” олонхийн ашиг дээгүүр хэмжигдэж, харин цөөнхийнх доогуур хэмжигдэн хохирохыг зөвшөөрдөггүй. Тиймээс “зүй”-г барьж нийгэмд иргэний эрхүүд тэнцүүгээр хийгдсэн. Аливаа эрхүүдэд түшиглэсэн “зүй” политикин тохиролцооны бус, мөн социал сонирхлуудын объект биш.

Буруу теоригоор хүн хэзээ ханамжтай вэ гэхээр түүнээс дээр теоригүй үед үүнтэй ижил биш байдал хэдийд хэрэглэгдэдэг вэ гэхлээр түүнээс дээш биш байдлыг устгахад чухал бол хүмүүсийн хийх акцуудын гол эрдэм үнэн ба “зүй” хоёрыг хэзээ ч тохиролцоогоор шийдэж болохгүй гэдэг.

Энд ярьж буй субъект “зүй” хаа ч тааралдах ёстой гэсэн бидний интуитив үнэмшил. Мэдээж энд дүрсэлсэн дүрслэл хурц. Ямар ч гэсэн би энд ярьж буй баталгаануудыг хэр ухамсартай гэдгийг шинжилнэ. Мөн цаашлаад ухамсартай тохиолдолд тэдгээрийг баталгаажуулна. Үүний тулд “зүй”-гийн тухай теорийг хөгжүүлэх чухал ба ингэснээрээ дээрхи баталгаануудыг тодруулж ялгааг гаргана. Би “зүй”-гийн тухай суурь сургаалаас эхэлнэ. Эхлээд нийгэм гэдэг их ч, бага ч битүүлэгдсэн хүмүүсийн нэгдэл ба тэдний хоорондын релацад ямар нэг замаар биеэ авч явах горимуудыг таньж, мэдэх ба ихэнхидээ түүгээр залагдана. Цааш хэлэхэд дүрмүүд хамтын ажиллагааны системийг тодорхойлдог ба тэр оролцогч тус бүрийн таатай нөхцөлд зориулагдана. Тэгэхээр нийгэм гэдэг хэний ч ашгийг дэмждэг үйл хэрэг ба характерынхаа хувьд зөвхөн сонирхлууд таарч тохирох биш бас зөрчилдөөн дагалдана.

Сонирхол таарч тохирох гэдэг нийгмийн хамтын хөдөлмөр бүгдэд амьдралаа сайжруулах боломж өгнө гэсэн үг. Сонирхлын зөрчил гэдэг хамтын хөдөлмөрөөс үүссэн бүтээгдэхүүнийг хэрхэн хуваарьлах асуулт ба яагаад гэвэл хүн бүр л илүү ихийг хүртэх гэдэг. Тиймээс суурь сургаалууд чухал. Үүний шалтгаан бүтээгдэхүүний хуваарилалтыг хэрхэн зохицуулах нийгмийн дүрэм горимуудыг шийдэж, үүний талаар тохиролцоонд хүрэхийг зорих чухал. Дараахи бол социал “зүй”-гийн тухай суурь сургаалууд. Тэдгээр нийгмийн институцуудын эрх ба үүргийг чиглүүлнэ. Мөн тэдгээрүүд нийгмийн хамтын хөдөлмөрийн жимс шүүсийг бас дарамт хүндэрлүүдийг хуваарьлахыг заана.

Бид зөвхөн нийгмийн гишүүн бүрийн ая тухаар тухайн нийгмийг журамтай гэхгүй харин хамтын “зүй”-гийн тухай төсөөллүүдээр үр нөлөөтэй залуулснаар дэг журамтай нийгэм гэнэ. Тэгэхээр энд хүн бүр адилхан “зүй”-гийн тухай суурь сургаалуудыг танин мэдсэн, мөн хүн бүр бусдыгаа мэдсэн гэдгийг, түүнчлэн нийгмийн суурь институцууд дээрхи сургаалуудыг хүлээн зөвшөөрсөн нийгмийн тухай ярих гэж байна.

Мэдээж ийм нөхцөлд хүмүүс бусаддаа хэтрүүлсэн шаардлага тавина. Тиймээс тэд хамтын масштабыг таньсан. Үүний үр дүнд шаардлагуудаа ялгах боломжтой. Хувийн ашиг сонирхол хүн бүрийг өөрийнхөө замаар явахыг тулгадаг ч “зүй”-гийн тухай хамтын мэдрэмж хүмүүсийг нэгдэн ажиллах боломжтой болгодог. Янз бүрийн зорилготой хүмүүсийн хооронд хамтын “зүй”-гийн тухай төсөөллүүд иргэдийн энх тайвныг сахиулдаг. Генэралчлагдсан “зүй”-гийн тухай эрмэлзлэл тус бүрдээ ялгаатай зорилгуудыг хязгаарладаг. Тэгэхээр дэг журамтай хүний нийгмийн суурь хууль /конституц/ бол хамтын “зүй”-гийн тухай төсөөлөл.

Үнэхээр нийгмүүд ховорхноор дээрхитэй адил тийм ч дэг журамтай биш. Яагаад гэвэл “зүй” ба “зүй” биш хоёр маргаантай. Хүмүүс нийгмийн хамтын амьдралынхаа

үндсэн дүрмүүдэд санал нэгтэй биш, тэглээ ч гэсэн хүмүүст “зүй”-гийн тухай төсөөлөл бий. Хүмүүс хүний үндсэн эрх болон үндсэн үүргийг зайлшгүй гэдгийг мэддэг, бас нийгмийн хамтын ажил хөдөлмөр дэх ашигтай болон саадтай субъектийн хуваарьлалтыг хэрхэн ба буруу гэдгийг таньдаг. Тэгэхээр хүн хэдийгээр олон төрлийн “зүй”-гийн тухай төсөөллүүдтэй ч эндээс бас “зүй”-гийн тухай ойлголтыг бодох боломжтой. Хэрэв нийгмийн үндсэн эрхүүд болон үндсэн үүргүүд хүмүүсийн хооронд дураар ялгавар гаргахгүй, мөн нийгмийн дүрмүүд хоорондоо өрсөлдөх тансаг амьдралын төлөөх өрсөлдөөнийг тэнцүүлж чаддаг бол хэдийгээр хүмүүсийн “зүй”-гийн тухай төсөөллүүд ялгаатай ч институциуд “зүй” шүү гэдэгтэй санал нийлдэг. Ингэж институциудын “зүй” санал нэгдэх боломжтой ба дураараа ялгаварлах тухай болон утгатай тэнцүүлэл зэрэг “зүй”-гийн тухай ухагдахуунууд дотор орсон. Эдгээрийн тодорхойлол хүмүүсийн эрх ба үүргүүд хэдий хэр адил талуудтай мөн хэдий хэр зөрөөтэйг тодорхойлдог. Энд бас бүтээгдэхүүний хуваарьлалт хэр зөвийг тодорхойлдог.

“Зүй”-гийн болон нэг бүрчилсэн төсөөллүүдийн тухай, ухагдахуунуудын тухай ялгаа мэдээж чухал асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Энэ зөвхөн социал “зүй”-гийн тухай суурь зарчмуудын ролиудыг мэдэхэд үүрэг гүйцэтгэдэг.

“Зүй”-гийн тухай төсөөллүүд нэгдмэл, бүрэн ажиллагаатай, хүний нийгмийн цорын ганц урьдчилсан нөхцөл биш. Үүнээс илүү социал проблемууд буй жишээлбэл координац, эффицэнт мөн стабилитэт. Нэг бүрчилсэн хүмүүсийн төлөвлөгөө нийгэмд ямар хэмжээнд зохицуулагдсан вэ гэхээр хийж буй хөдөлмөр хоорондоо авцалдаатай, мөн бүгд хамтран ажиллагаагаа явуулдаг, цаашилбал хэн нэгний хүссэн биелэгдэхгүй үед сэтгэлээр унахааргүй хичээх ёстой. Энэ хамтын ажиллагаа нийгмийн зорилгуудыг биелүүлэхэд зориулсан ба түүгээр ч барахгүй өндөр ашигт актын коэффициенттэй бас “зүй”-н замаар явагдана. Эцсийн эцэст нийгмийн хамтын хөдөлмөрийн схем стабил болох хэрэгтэй. Боломжоороо үүний төлөө хичээх хэрэгтэй ба гол дүрмүүдээ бас нийтээрээ сахих ёстой. Эдгээрийг зөрчвөл зөрчлүүдийн эсрэг үйлчлэх хүч мөн дүрэм журмыг сахиулах хүчнүүд болох ёстой. Эдгээр гурван проблемууд “зүй”-гийн тухай проблемуудтай хамаатай. “Зүй”-тэй эсвэл “зүй”-гүйн талаар хүмүүс нэгдсэн нэгдэлгүйгээр хамтын хөдөлмөр таарч тохироход хүндрэлтэй бөгөөд хэн хэндээ ашигтайгаар релац үүсэхэд ч бас хүндрэлтэй. **Хэн хэндээ итгэлцэхгүй байдал нийгмийн холбоосыг тасалдаг.**

Мөн хардаж сэрдэх дайсагнах байдал хүмүүсийг хэзээ ч хийхгүй актууд руу толгойг эргүүлдэг. “Зүй”-гийн тухай, төсөөллийн тухай энэ онцлогууд суурь эрхийг болон суурь үүргийг тохиролцох, мөн хуваарьлахыг шаарддаг. Эдгээр бол эффицэнт, координат, болон стабилитэт гурваас хамааралтай. Хэдийгээр “зүй”-гийн тухай төсөөлөл “зүй”-гийн тухай ухагдахууныг тодорхойлоход чухал ч гэсэн зөвхөн ганцаараа тэнцүү хувиарлалтанд нөлөөлөхгүй. Тэгэхээр хүн түүний бусад салаануудыг анхаарах хэрэгтэй. “Зүй” бол институциудын чухал эрдэм учраас хамгийн эн тэргүүнд тавигдах ёстой. Тэглээ ч тухайн үед зарим “зүй”-гийн тухай төсөөллүүд хэдийгээр урт хугацаанд ашиггүй ч сайн мэтээр сонгогдоно.

“Зүй”-гийн субъектууд

Хүн олон субъектуудыг “зүй” эсвэл “зүй” биш гэдэг. Эдгээр бол зөвхөн хууль тогтоолууд, институциуд болон нийгмийн системүүд биш харин янз бүрийн хүний акцууд бий. Жишээлбэл шийдлүүд ялгаж буй ялгаврууд болон моралийн үнэлгээнүүд. Тэр ч бүү хэл хүний хандлагуудыг, мөн биеэ авч явж буйг ч бусад хүмүүс “зүй”-тэй эсвэл “зүй”-гүй гэдэг. Гэхдээ бид энд социал “зүй”-гийн тухай ярьж буй. Бидний хувьд “зүй”-гийн тухай анхны объект, нийгмийн суурь структур. Яг хэлэхэд нийгмийн чухал институциуд үндсэн эрхүүдийг болон үндсэн үүргүүдийг, мөн нийгмийн хамтын хөдөлмөрийн ашгуудыг хэрхэн хувиарьялаж буй төлвийг хэлнэ. Чухал институц гэдгээр би ойлгосон ба эхлээд конституцаа, цаашлаад чухал эдийн засгийн болон социал релацуудыг тэдгээрийн жишээнүүд, бодлын фрийдом болон үнэмшлийн фрийдомыг хуульчлан баталгаажуулах, зах зээлд өрсөлдсөн уралдаанууд орших, үйлдвэрийн хэрэгслийг хувь хүн эзэмших

боломж, мөн гэр бүл, моногами буюу нэг эхнэр, нэг нөхөр гэсэн зарчимд тулгуурлах гэх мэт. Бүгд нийлсэн энэ институц хүний эрх болон үүргийг тодорхойлох ба тэдний амьдралын шаансуудад нөлөөлж, хүн хэн болох боломж, мөн тэд хэдий хэр сайн болох боломж зэрэгт нөлөөлнө. Суурь структур бол “зүй”-гийн тухай гол объект. Тэдний үйлчлэлүүд гүн ба эхнээсээ л агуулагдана. Хүн интигтивээр төсөөлөх боломжид олон төрлийн социал позицууд бий, нийгэмд шинээр төрж буй хүн янз бүрийн шаансуудыг эдэлдэг. Тэдний нэг хэсэг политикийн системээс нөгөө хэсэг эдийн засгийн болон социал релацуудаас хамаардаг.

Нийгмийн институциуд зарим амьдралын гараануудыг тааламжтай болгодог. Эдгээр бол гүн гүнзгий тэнцүү биш байдлууд. Тэдгээр зөвхөн хаа ч үйлчлэх биш, мөн хүн бүрийн амьдралын гарааны анхны шаансуудад нөлөөлдөг. Харин анхны шаансуудад хувь хүн гийгүүлээгүй, мөн гавъяа байгуулаагүй. Энэ мэт тэнцүү биш байдлуудыг аль ч нийгмийн суурь структуруудад арилгах боломжгүй, тиймээс социал “зүй”-гийн тухай суурь зарчмууд хамгийн түрүүнд үүнийг тусгах ёстой. Эдгээрүүд түүний дараа политикийг тодорхойлно, мөн эдийн засгийн болон социал системийн гол чиглэлийг бас тодорхойлно. Нийгмийн моделийн “зүй” ихэвчлэн хамаарал үндсэн эрхүүд болон үндсэн үүргүүд, эдийн засгийн боломжууд, мөн социал релацууд нийгмийн янз бүрийн салбаруудад хэрхэн тодорхойлогдсоноос хамаарна.

Бидний шинжилгээ хоёр субъект дээр хязгаарлагдмал. Эхлээд би “зүй”-гийн тухай проблемийн онцлог дээр ажиллана. Би институциудын “зүй” болон нийгмийн ажиллагаануудыг генералаар авч үзэхгүй бас иргэдийн эрхүүдийн тухай “зүй” болон төрийн хоорондын релацын “зүй”-г зөвхөн дурьдана. “Зүй”-гийн тухай ухагдахууныг авч үзэхдээ хэрхэн хэрэглэгдэж буйг л сонирхоно. Суурь структурууд тохиолдол бүрт хүчинтэй болох албагүй. Эдгээр хувь хүмүүсийн байгууллагууд болон нийгэм дэх цөөн групп хүмүүсийн хувьд хэрэгцээгүй. Магадгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын заншил болон тогтсон ёснуудад ямарч хамаагүй. Тэдгээр “зүй”-гийн тухай хэлээгүй магадгүй фейрнесийн тухай ч гэсэн, сайн дураараа нийлсэн нийгэмлэгүүдийн тухай ч гэсэн, мөн контракт хийсэн хүмүүсийн дүрмийн тухай ч гэсэн.

Хэрэв би нийгмийн суурь структурт зориулсан ухамсарт “зүй”-гийн тухай ухагдахууныг томъёолж чадвал сэтгэл ханамжтай бөгөөд бид энд ярьж буй нийгмийг эхлээд хаалттай систем гэж төсөөлөх ёстой. Энэ бусад нийгэмтэй холбогдоогүй гэсэн үг. Энэ онцгой тохиолдол илэрхийгээр хүрэлцээтэй утга агуулсан. Энд тавьсан таамаглал хэрэгцээтэй теори гаргаж чадвал бусад “зүй”-гийн тухай проблемуудыг хэлэлцэхэд хөнгөвчлөх. Зарим өөрчлөлтүүдийг хэрэглэснээр тиймэрхүү теори, зарим ондоо проблемуудыг шийдвэрлэх түлхүүр болох боломжтой.

Энд бидний ярилцаж буй субъектын өөр нэг хязгаарлалт бол би “зүй”-гийн тухай суурь сургаалуудыг ярихдаа зохион байгуулалтанд орж чадсан нийгмүүдийг ихэнхидээ авч үзсэн. Урьдчилсан хэд хэдэн нөхцлүүдийг энд ярих хэрэгтэй. Жишээлбэл хүн бүр “зүй”-тэй хийдэг, мөн хүн бүр өөрийнхөө үүрэг хариуцлагаа “зүй”-н институциудад оролцоогоо зориулдаг. “Зүй” магадгүй Хюмийн хэлснээр болгоомжтой, хардалт сэрдэлттэй эрдэм. Тэгсэн хэдий ч төгс “зүй” мөн нийгэм ямрыг бид асуух хэрэгтэй. Хамгийн түрүүнд би бүрэн биш конформетэдийн теоригийн эсрэг бүрэн конформетэдийг хэлэлцэнэ. Эдгээр “зүй” биш өөрөөр хэлбэл “зүй”-гүйг судлахад хэрэглэгдэнэ. Үүнд шийтгэлийн теори, “зүй” дайны теори, “зүй” биш дарангуйллын эсрэг олон төрлийн “зүй” эсэргүүцэх хөдөлгөөнүүдийн теори, иргэний хүлцэнгүйгийн теори, цэрэгт явахаас татгалзах теоригоос авахуулаад идэвхитэй бослого мөн хувьсгалууд. Тэдгээрт бас хамаардагууд тэнцүүлсэн “зүй” мөн институциудын хоорондын “зүй” бишүүд орно.

Хэрэг дээрээ бүрэн биш конформетэдийн теоригийн проблем хамгийн яаралтай мэт. Тэдэнтэй бид өдөр тутмын амьдралдаа тааралддаг. Хэрвээ би идеалчлагдсан теоригоос эхэлнэ гэвэл үүний шалтгаан яаралтай проблемуудыг системчлэн хэлэлцэхэд

цорын ганц суурь. Жишээлбэл түүн дээр иргэний хүлцэнгүйгийн маргаан тулгуурладаг. Үүнээс өөрөөр би гүн ойлгох боломжгүй. Би төгс “зүй”-тэй нийгэм гэдгээр зүйтэйгийн теоригийн үндсэн хэсэг гэж үздэг.

Шууд хэлэхэд суурь структурын ухагдахуунууд энд тодорхойлогдоогүй. Түүнд ямар институциуд, мөн ямар функциуд хамаарах бол хэзээд тодорхой биш. Тэглээ ч энэ тухай бодож эхлэх арай л эртэдсэн. Би хамгийн түрүүнд суурь асуудлуудаа ярилцах ба үүнд хэрэглэгдэх субъектууд бидний интуицээр суурь структурт хамаарагдана. Дараа би суурь асуудлуудынхаа хэрэглээг өргөтгөнө. Тэгснээрээ структурын гол хэсгүүд боловсруулагдана. Магадгүй суурь асуудлууд бүхлээрээ генэрал болох талтай. Гэхдээ л үүний магад бага. Социал “зүй”-гийн тухай чухал асуудлуудыг авч үзвэл хангалттай шүү дээ. Бидний мартаж болохгүй суурь структурын “зүй”-гийн тухай ухагдахуун өөрөө үнэт. Хэдийгээр суурь асуудлууд газар бүр хэрэг болохгүй ч түүнээс татгалзах ёсгүй. Социал “зүй”-гийн тухай нэг ухагдахуун хамгийн түрүүнд нийгмийн суурь структурын хэрхэн хуваарьлаж буй шинжийг ялгахад масштаб болдог. Гэхдээ бусад төрлийн эрдэмүүдийг тодорхойлдог суурь асуудлуудтай сольж болохгүй. Суурь структур ба нийгэм дэх социал релацууд дээгүүр эсвэл доогуур ашигт актын коэффициенттойгоор ажиллаж чаддаг, бас фрийдомтой, мөн фрийдомгүй ч.

“Зүй”- эсвэл “зүй”-гүүгийн хажуугаар бусад шинжүүд ч олон. Бүхий л эрдэмүүдэд зориулсан суурь асуудлуудын тухай нийтлэг төсөөлөл нийгмийн зөрчилтэй асуудлуудтай хамтран “зүй”-гийн тухай ухагдахуунаас ч илүү ойлголт. Энэ бол нийгмийн идеал. “Зүй”-гийн тухай суурь асуудлууд тэдгээрийн зөвхөн нэг хэсэг биш харин ч магадгүй чухал. Нийгмийн идеал, нийгмийн төсөөлөлтэй хамаатай. Өөрөөр хэлбэл нийгмийн хамтын хөдөлмөрийн зорилгуудын визион. “Зүй”-гийн тухай төсөөллүүдийн янз бүрийн байдал хүний амьдралын натураасаа зайлшгүй ба боломжуудын янз бүрийн төсөөллүүдийн цаад учраас гаралтай нийгмийн янз бүрийн төсөөллүүдээс эхлэлтэй. **Хэрэв хүн “зүй”-гийн тухай төсөөллийг бүрэн ойлгоё гэвэл түүнд суурилсан төсөөллийг нийгмийн хамтын хөдөлмөрөөс гаргах хэрэг болно. Гэхдээ л хүн “зүй”-гийн тухай суурь асуудлуудын болон түүний гол субъектуудийн онцгой ролиудыг хараанаасаа салгаж болохгүй.**

Удиртгалын хэсэгт би хоорондоо өрсөлдсөн хэрэгцээнүүдийг хэрхэн тохиромжтойгоор тэнцүүлэх тухай “зүй”-гийн тухай ухагдахуун болон тэнцүүлэхийг тодорхойлох, хоорондоо хамааралтай чухал суурь зарчмуудын тухай, “зүй”-гийн тухай төсөөллүүдийн хоорондох ялгааг ялган харуулсан. Шулуухан хэлэхэд “зүй” гэдгийг нийгмийн идеалийн нэг хэсэг гэж би тодорхойлсон. Гэхдээ миний гаргасан теори “зүй”-гийн тухай өдөр тутмын ойлголтыг өргөтгөсөн. Энэ теори өдөр тутмын утгуудыг тайлбарлаагүй, харин нийгмийн суурь структурт зориулсан тодорхой хуваарьлалтын суурь зарчмуудыг тайлбарласан. Миний бодлоор боломжоороо бүрэн хийгдсэн этикийн теори дээрхи суури проблемуудыг шийдэх суурь зарчмуудыг агуулах ёстой. Тэдгээр ямар байдлаар ч хийгдсэн тэдний “зүй”-гийн тухай теориг гарган тавина.

“Зүй”-гийн тухай ухагдахуун хэрхэн тодорхойлогдох вэ? Эрх ба үүргийг хэрхэн олгох суурь зарчмуудаараа мөн нийгмийн сайчуудыг хуваарилснаараа тодорхойлогдоно. Эдгээрийн функцын илэрхийлэл бол “зүй”-гийн тухай төсөөлөл.

Магадгүй эдгээрүүд одоогийн традицуудтай таарч тохирохгүйгээр бидэнд тусаж болох ингэж ч би үзэхгүй. Аристотел “зүй”-гийн тухай сургаалд яг таарсан учрыг өгсөн ба эдгээрээс ч бусад сургаалууд гаралтай. Түүнийхээр плеонексиагаас татгалзах. Энэ бусдын юмыг булааж, өөртөө давуу талыг гаргах, жишээлбэл өмчийг булаах, байгуулсан гавъяаг булаах, албан тушаалыг нь булаах, мөн бусдад хамаатай субъектыг нуун дарагдуулах. Цаашилбал амлалтаа биелүүлэхгүй, өрөө төлөхгүй, үзүүлэх ёстой тусламжаасаа татгалзах зэрэг. Эдгээр тодорхойлолтууд хэрэг дээр түшиглэсэн ба хүмүүс “зүй” субьектийг хийж актлах гэсэн тогтвортой үр нөлөөтэй хүслийг характераа болгосон цагт “зүй” гэж хэлэгддэг. Аристотелийн тодорхойлолт ямар анализыг урьдчилсан нөхцөл болгосон бэ гэхээр хүнд “зүй”-гээрээ ноогдох ёстой болон мөн хүмүүс авах “зүй”-г илэрхийлсэн.

Минийхээр эдгээр авах “зүй”-гийн тухай ойлголт социал институцээс урган гарах ёстой. Аристотелийг дээрхитэй санаа нэг биш гэж тааварлах шалтгаангүй бөгөөд тэр социал “зүй”-гийн тухай төсөөллүүдтэй.

Миний тодорхойлолт чухал субъектийг хамааруулсан. Суурь структурын “зүй” традицтай харшлахгүй.

Даваасүрэнгийн САНЧИР

Соён гэгээрэл гэдэг өөрийн буруугаас амаа таглахаас салах гарц.


Кант.


Философи гэдэг хүмүүст харуулдаг урлаг биш.

Философи гэдэг үгэн дээр бус үйлдэл дээр тогтоно.

Философи хүний оюуныг боловсруулна, амьдралыг замбараажуулна, үйлдлийг тодорхойлно. Хүмүүст юуг хийхийг бас юуг орхийг заадаг.

Сенека.





Карл Маркс /Германы философич, 1818-1883/

Байх ба ухаан (“Политикчимон экономийн критик” номын өмнөх үг)

Хүмүүс өөрсдийнхөө амьдралд зориулсан нийгмийн бүтээгдэхүүн гаргах явцдаа тодорхой, зайлшгүй мөн өөрсдийнхөө хүслээс хамааралгүй харьцаанд оролцдог. Энэ харьцааг бүтээх харьцаанууд гэх ба хөгжлийн тодорхой төвшинд хүмүүсийн материаллаг бүтээгч хүчтэй таардаг. Энэ бүтээх харьцаануудын нийлбэр нийгмийн экономын структурыг байгуулдаг ба үүнийг реал бааз гэнэ. Энэ бааз дээр хуульчилсан болон улс төржсөн барилга босох ба тэр барилга тодорхой нийгмийн формуудтай таардаг. Материаллаг амьдралын бүтээгдэхүүний шинж социал, социалчилсан, политикчилсон болон оюунчилсан амьдралын процессыг нөхцөлдүүлнэ. **Тиймээс хүний ухаан түүний байхыг тодорхойлохгүй, харин урвуугаар хүмүүс хэрхэн нийгэмд байгаа тэдний ухааныг тодорхойлно.**

Нийгмийн хөгжил тодорхой төвшинд хүрэх үед нийгмийн материаллаг бүтээгч хүчүүд өгөгдсөн бүтээх харьцаануудтай зөрчилдөнө, эсвэл хуулийн хэллэгээр өмчийн харьцаануудтай зөрчилдөнө. Яагаад гэвэл тэд энэ л хүрээн дотор явцгаасан. Бүтээгч хүчүүдийн хөгжлийн формууд дээрхи харьцаануудыг оосорлон хүлдэг. Үүний дараа социалын революцын эрин эхэлдэг. Экономын сууриудыг өөрчилж эхэлснээр дээр хэлсэн аймшигт том барилга удаан эсвэл шахуу хувирна. Ийм хувиралыг ажиглах үед юуг үргэлж ялгах ёстой вэ гэхээр нэг талаас экономчилсон бүтээгдэхүүний нөхцлүүд доторхи материаллаг болон натурын сайэнсийг чухалчилсан хувьралт, харин нөгөө талаас хуульчилсан, политикчилсон, шашинчилсан, урлагчилсан эсвэл философичилсон буюу товчоор идеологичилсон формуудыг ялгах ёстой ба үүнд хүмүүс дээрх зөрчилдөөнийг ухаарах ба тэмцэнэ.

Индивидум гэж юу вэ гэдгийг ялгаж чадахгүйтэй адил, дээрх хувьслын эринийг хүмүүсийн ухаанаар ялгах боломжгүйтэй адил тэдний ухааныг амьдралын зөрчлүүдээс нь илүү тайлбарлах боломжтой. Тэр зөрчил нийгмийн бүтээгч хүчүүд ба бүтээх харьцаануудын хоорондын зөрчил.

Бүхий л бүтээгч хүчүүд хөгжиж гүйцээгүй цагт нийгмийн формац хэзээ ч унадаггүй ба материаллаг эксистенц нөхцлүүд хуучин нийгмийн өвөр дээр өсөж торнисон цагт шинэ дээгүүр бүтээх харьцаанууд гарч ирэхгүй. Тиймээс хүн төрөлхтөн зөвхөн шийдэж чадах даалгавруудын өмнө зогсоно. Яагаад гэвэл тэдгээрийн шийдлийн материаллаг нөхцлүүд эртнээс өгөгдсөн ба эсвэл наанадаж болох процесс дотор агуулагдсан. Томоор хэлэхэд азийн, антикийн феодалын болон модерн иргэнжсэн бүтээх

шинжүүдийг экономчилсон нийгмийн формацын прогрессив эрин гэдгээр нэрлэх боломжтой.

Иргэнчилсэн бүтээх харьцаанууд нийгэмчилсэн бүтээх процессийн сүүлчийн антагонист форм. Антагонист гэдгээрээ индивидуал антагонизмын утгаараа биш харин индивидуумын нийгмийн амьдралын нөхцлүүдээс урган гарсан антагонизм. Гэхдээ иргэний нийгмийн өвөр дээр хөгжсөн бүтээгч хүчүүд дээрх антагонизмын материаллаг нөхцлүүдийг гаргадаг. Энэ нийгмийн формацын хамтаар хүний нийгмийн өмнөх түүх төгсдөг.

- ✓ Бүтээгч хүч
- ✓ Бүтээх харицаа
- ✓ Антагонизм
- ✓ Формац
- ✓ Революц
- ✓ Идеологи

Нэргүйн БААСАНХҮҮ

Зүй ба амьдралын чанар



Марта Нуссбаум /Америкийн философич/

Марта Нуссбаум 1947 оны 5 сарын 6-нд төрсөн Америкийн философич. Тэр эртний Грек ба Ромын философи болон Политикийн философи, Этикийн чиглэлээр судалгаа хийдэг.

Түүний гол зохиолууд “Сайны хэврэгшил: Грекийн трагед ба философийн аз, этик” /1986/, “Боловсорсон хүн төрөлхтөн” /1997/, “Секс ба социал зүй” /1998/, “Хүн төрөлхтөнөөс нуугдах нь” /2004/, Амарта Сентэй хамтран “Амьдралын чанар” /1993/ гэх мэт олон бүтээл туурвижээ.

Зүйг чухалчлах уу эсвэл сайн амьдралыг чухалчилах уу гэсэн философийн эртний асуултуудыг Америкийн философч эмэгтэй Нуссбаум нухацтайгаар бодож түүнийгээ бүтээл болгон бичжээ.

Аристотелоос эхлэлтэй философийн эртний сэдэв бол сайн амьдрал мөн сайн төр. Тиймээс Нуссбаум төрийн даалгавар хамгийн түрүүнд сайн амьдралыг нэгдүгээрт тавихыг чухалчилж зайлшгүй урдуурчилахыг энэ номоороо баталсан.

Орчуулагч

Аристотелийн социалдэмократизм

Нэг. Иргэн хүн амьдралын хэрэгцээт зүйлсээр дутагдсаны улмаас зовох ёсгүй.

Аристотел хүний тухай болон хүний сайн амьдралын тухай ярьжээ. Тэр бас амьдралын олон салбарт төрийн институцийг зохион байгуулах талаар ярьсан. Тэдгээр нь түүнийхээр бол хууль хийгчдийн ажилд хамаарах ёстой. Аристотел төрийн төлөвлөгөө хийгчдийн даалгавруудад дээрхи хоёр зүйлсийг уялдуулсан. Тэр даалгавар нь иргэн бүрт материалын, институцийн болон сурган хүмүүжүүлэхийн нөхцлүүдийг бий болгох, тэгснээрээ хүн сайн амьдралд зам нь нээгдэж, мөн хүнийг сайн амьдрал, сайн үйлдлийн төлөө шийдэл гаргах боломжтой болгоно гэжээ. Би энд Аристотелийн бодолд тулгуурласан улс төрийн концепцэд философийн тодорхойлолт өгсөн. Энэ концепц нь ямар нэг хэлбэрээр либерализмийг илэрхийлэх ба мөн энэ концепцийг үнэтэй бас нилээд найдлагатай гэдгийг тодруулсан. Дээр гарчигт хэлсэнчлэн энэ концепц

социалдемократизмийн тодорхой вариантуудыг философийн үүднээс судалсан концепцийг гаргасан. Энэ вариант өнөө үеийн хэлэлцүүлгүүдэд нэг талаас либерализмийг хуваалцдаг, нөгөө талаас шийдвэрлэх асуудлууд дээр либерализмыг няцаадаг. Бид концепцдоо шинжилгээ хийхийн тулд дараах гурван зүйлийг Аристотелийн “Politik” номоос ажиглацгаая.

Бидний биед хамгийн их, цаг үргэлж хэрэгцээтэй зүйлс бол эрүүл мэнд, ус, агаар гэсэн байгалийн нөлөөлөлүүд. Тиймээс нэг талын баримжаатай төрийн хувьд зөвхөн уухад зориулсан ус мөн, бусад хэрэгцээнд зориулсан ус гэж заавал ялган салгадаг (politik 1330 b ii).

Ингээд тариачны хувьд хэнд юу ноогдох тухай ярилцъя. Жишээлбэл эзэмшил бол хамтынх байж болохгүй. Харин найз нөхдийн дунд хамтынх болгож болно. Нөгөөтэйгүүр хэн нэгэн төрийн иргэн амьдралын хэрэгцээгээр дутагдан зовж болохгүй. Хамтдаа өдрийн хоол, оройн хоол заавал идэх бол зөв зохион байгуулалттай төрийн илэрхийлэл. Үүнд бүхий л төрийн иргэд оролцох ёстой. Гэтэл ядуу хүмүүс өөрийнхөө хувийг нийлүүлж, үүний хажуугаар мөн өөрийнхөө гэр аж ахуйг хангахад хүндрэлтэй. Тиймээс газар эзэмшлийг газрын дээр ба газрын доорхи гэж хоёр хэсэгт хуваах шаардлагатай ба газрын доорхи хамтын эзэмшил харин газрын дээрхи хөрс нь хувийн эзэмшил. Энэ хоёр хэсэг дотроо хоёр хуваагдах ба нэг нь бурхны буюу буяны үйлсэд зориулсан, нөгөө нь өөрт хоол унданд зориулсан. Ингэснээрээ тэнцүү байдал, зүйт буюу зөв байдал биелэгдэнэ (politik 1329 b 39).

Төрийн тэргүүний засаглал гэдэг бол чөлөөт болон тэнцүү хүмүүсийг удирдах (politik 1255 b 20).

Дээрхи гурван иш татлалын нэгд огцом шилжилт явагдсан. Ус болон агаар эрүүл мэндэд маш чухал. Тиймээс хүний сайн амьдралын гол хэсэг бол энэ ресурсыг хүртээмжтэйгээр бэлэн байлгах ба энэ бол төрийн үүрэг.

Хоёрдугаар иш татлал мөн дээрхитэй ойролцоо алхам хийгдсэн ба сонирхолтой үр дүнд хүрчээ. Дараахи байдлаар аргументалсан байна. Үүнд: хамтаараа өдрийн болон оройн хоолтой байх социал амьдралын үнэт хэсэг. Гэтэл хязгааргүйгээр хувийн өмчтэй системийн хувьд ядуучууд оролцох боломжгүй нөхцлийг үүсгэдэг. Ингэснээрээ төрийн иргэн экзистенцийн үнэт хэсгээ алддаг. Энд нэрлээгүй нэг асуудал бол ерөөс хувийн өмчгүй системийг зөвшөөрөх боломжгүй. Аристотелийн дүгнэлтээр бид ямар системийг хүсч байна вэ гэхлээр нэг талаас хувийн өмчид тодорхой хэм хэмжээ өгөх ёстой. Нөгөө талаас иргэн бүр амьдралын хэрэгцээгээр дутагдаж, зовох ёсгүй. Хамтын хоол ундны хувьд ч гэсэн мөн бусад үнэтэй гэж үнэлдэг үнэтүүдийн хувьд ч гэсэн энд санал болгож буй шийдэл өнөөгийн хүмүүнлэг төрийн өнцгөөс харахад хэвийн биш. Яагаад гэвэл газрын хөрс ба газрын доорхи хоёрын талыг нь хамтын өмч гэж тодорхойлж байгаа тул энэ хоёроос орох орлогын тал нь олон нийтийн зардлыг төлөх ёстой. (Жишээлбэл: дуурийн урлаг, драмын урлаг, урлагийн тоглолтууд, түүний хажуугаар сурган хүмүүжүүлэх болон култур боловсрол). Үлдсэн нь бол бүхий л иргэд хамтын хоол ундаар хангагдах.

Аристотел өөрийнхөө энэ шийдэлд проблем буйг анзаарсан. Хамтын хоол унд бол бүх иргэдийг тэжээхэд чухал үүрэгтэй. Мөн олон нийтийг эв нэгдүүлэхэд чиглэгдсэн (1272 a 19-20). Жишээ нь спартчууд иргэн бүрээс хамтын хоол унданд өөрийнхөө хувийг нийлүүлэхийг шаарддаг. Хэрвээ хэн нэгэн иргэн өөрийнхөө хувийг нийлүүлж чадахгүй бол хамтын хоол унданд оролцохоос хасагдах ба түүгээр ч барахгүй шийтгэл хүлээдэг. Тэр шийтгэл үндсэн хуулийн зүйл ангиуд тэр иргэнд биелэгдэхээ болидог. Аристотел энэ системийг шүүмжилсэн ба харин Кератануудын системийг магтсан. Энэ систем бол нийтэчийг илтгэсэн характертай. Тэднийхээр бол хамтын хоол унд нь мал аж ахуйн орлогоос төлөгдөх ба мөн хамтын газар нутгийн жимс жимсгэний орлогоор ч бас төлөгдөнө. Энэ Аристотелийн идеал төрийн модел нь Кератануудын төрийн моделд ойртсон ба тэр ч бүү хэл энэ моделийг ч давсан. Яагаад гэвэл Аристотел төрийн иргэн биш

хүмүүсээс орлогын татвар авах боломжгүй тул газрын хөрс ба газрын доорхийн ихэнхи хэсэг хамтын үйл хэрэгт зориулагдах ёстой гэжээ.

Энэ бүгд тийм ч хангалттай биш. Аристотел хувийн эзэмшилд буй газрыг хүртэл хамтын хэрэгцээнд зориулагдах боломжтой болгох ёстой гэсэн. Үүгээрээ тэр юуг хэлж байна вэ? Түүний номын хоёрдугаар дэвтэрт бичсэнээр “Хууль гаргагчид иргэд өөрийн эзэмшлээ зөвхөн дотны найз нөхөддөө эдлүүлэх биш, мөн хамтын хэрэгцээнд зориулах ёстой гэж хууличлах нь зөв” гэжээ. Тэр бас хэд хэдэн жишээг хэлсэн байна. Үүнд хэрэв хүмүүст хэрэгцээтэй бол бусдын боол, мөн морь болон нохойг ч хэрэглэж болох ба талбайд нь ургасан жимс жимсгэнийг хэн ч хэрэглэж болно гэжээ(1263 а 30).

Аристотел хууль гаргагчдыг хэрхэн энэ зорилгод хүрч болохыг биднээс нуугаагүй. Хамгийн тодорхой нь Аристотелийн энэ л төрийн иргэн бүр дуртай цагтаа аж амьдралдаа хэрэгцээт зүйлээр хангагдах боломжтойгоор зохицуулагдсан, тэр ч бүү хэл хувийн эзэмшил зөвшөөрөгдсөн газар хэн нэгэнд хэрэгцээ гарвал тэр эзэмшлээс нь хуваалцах зөв. Энэ бүгд ямар шалтгаануудаар тайлбарлагдсан бэ гэхээр зүй ба тэнцүү байдлын ёс /equality/ хоёрт зориулагдсан гэжээ.

Гуравдугаар иш татлал бол засгийн буюу засаглалын ямрыг тодорхойлсон. Аристотелийнхоор бол засаг чөлөөт хүмүүсийн болон тэнцүү нөхцөлтэй хүмүүсийг удирдах төрлөөр ажиллах ёстой гэжээ. Энд хоёр санаа гарч ирсэн ба засаглагч ч, засаглуулагч ч хоёулаа чөлөөтэй, мөн тэнцүү нөхцөлтэйгээр хийгдэх ёстой бөгөөд мөн үүнтэй адил хэзээ нэгэн цагт засаглагч засаглуулах, засаглуулагч засаглах боломжтойгоор харилцан солилцох нөхцлийг бүрдүүлэх ёстой гэжээ.

Энд бид гурван аспектиг авч ярьлаа. Нэгдүгээрт хүний сайн амьдралын концепц. Үүнийг энд гүнзгийрүүлэн ярилцахгүй ба бидний тодорхойлсноор юу гэж ойлгох вэ гэхээр хүний биеийн байдал, сайн мөн бусадтай сайнаар социал нөхцлүүдээр хангагдахыг хэлжээ. Хоёрдугаарт политикин засаглалын концепцийг авч үзсэн. Үүгээр бол сайн амьдралыг дэмжихийн тулд бүхий л нөхцлүүдийг бий болгож, бас тогтоон барих (Иргэн хүн амьдралын хэрэгцээгээр дутагдаж зовох ёсгүй), мөн иргэдтэй чөлөөт мөн тэнцүү нөхцөлтэйгөөр харицах ёстой. Гуравдугаарт институцийн суурь структурыг авч ярьсан бөгөөд хэдийгээр хувийн эзэмшлийг зөвшөөрсөн ч хоёр зүйлийг хязгаарлажээ. Нэгд хамтын өмч, хоёрт хувийн эзэмшлийг хугацаат зүйл гэж ойлгох. Энэ юу гэсэн үг вэ гэхээр бусдад хэрэгцээ гарвал зөвхөн хувийн эзэмшил гэхээ болино шүү гэсэн ойлголт. Энэ бүгдийг өөрөөр хэлбэл энэ дүрмүүдийг конкрет, деталчлан төсөөлөхөд хүндрэлтэй, харин юу гэсэн гол санаа бол тодорхой.

Энэ гурван аспектийн хоорондын холбоог би энд тодорхойлж, мөн дараахи зүйлийг гаргаж тавина. Юу вэ гэвэл энд ярьж буй хүний сайн амьдралын тухай дүгнэлт цаашаа политикин засаглалын тухай зөв ойлголтонд хүргэж, тэгснээрээ политикин концепц гаргах боломж олгох ёстой. Бид хамгийн түрүүнд юуг асуух вэ гэхээр хэрхэн Аристотелийн энэ концепцууд дээрхи зайлшгүй нөхцлүүдийг баталгаажуулах вэ? Хүний сайн амьдралын тухай теорийг хэрхэн томъёочлох вэ? Мөн үүний дараа төрийн ямар журам хамгийн сайн гэж шийдэх вэ?


Бидний судалгааны хамгийн том асуудал бол хүний сайн амьдралын тухай дүгнэлтийг шинжлэх, мөн цаашилбал Аристотел энэ дүгнэлтүүдэд хэрхэн хүрсэн тухай асуух. Би энд юуг харуулах вэ гэхлээр хүний сайн амьдралын тухай дүгнэлт хүн гэсэн концепцд тулгуурладаг болохыг харуулна. Энэ концепцийг би хүний эрчтэй вагэ концепц гэж нэрлэх ба мөн түүнтэй холбоотой сайн амьдралын концепцийг сайны эрчтэй вагэ концепц гэж нэрлэлээ. Яагаад би ингэж ялгасан бэ гэхээр зарим либерал теоринуудад сайны тухай концепцийг хэрхэн тусгаснаас заавал ялгах гэж. Үүгээрээ би юу хэлэх гэж буй вэ гэхээр миний энэ сайн амьдралын тухай концепци Жон Роулсын сул теориноос ялгаатай ба нилээд ерөнхий бөгөөд мөн олон спецификацуудыг агуулсан.

Хамгийн гол нэг зүйл бол хүний тухай энэ концепц метафизик биш шүү. Зарим либерал теоричид өөрийнхөө төсөөллөөр Аристотелийн эсрэг зогсдог. Энэ концепц бол илүү этик-политикийн концепц. Нилээд суурь болон ерөнхий төвшинд бөгөөд янз бүрийн культуруудад байдагтай адил тул интеркултурэлчлэгдсэн этик-политикийн судалгааг дүрсэлдэг. Бид Аристотелчсон концепц дотор шийдэх чөлөөт хэр их үүрэг гүйцэтгэж буйг харна. Мөн политикийн засаглал хэрхэн чөлөөт болон тэнцүү нөхцөлтэй иргэдийг засаглах тухай асууна. Бидний бас нэг асуух асуулт бол зорилгуудын хэрхэн плюрал спецификацууд буйг асуух. Эдгээр нь биднийг Жон Роулсын болон Роналд Дворкин нарын төлөөлсөн либерализмын вариантуудтай ямар харьцаатай болохыг харуулах ба мөн скандинавын социалдемократ теорины суурь ойлголтуудтай ойртуулна.

Батжаргалын ГАНСҮХ

ТӨРИЙН ФИЛОСОФИ

Төрийн теори



Томас Хоббс /Английн философич, 1588-1679/

Төрийн теори төрийн дефиницүүдийг, эх үүсвэрүүдийг, формуудыг, үүргүүд болон зорилгуудыг, мөн түүний институцийн, социалын, этикийн, хуулийн болзлуудыг ба хязгааруудыг судлах доктрин. Политикийн философийн, мөн нийт төрийн сургаалын тодорхойлолтын салбар гэх үүднээс төрийн теоринууд олон шинжит аспектуудыг хөнддөг. Эдгээр аспектууд олон салбарууд болон сайэнсуудын оролцоотой. Үүнд: *философи, теологи, политикийн сайэнс, эрхийн сайэнс, социологи, улс ардын аж ахуй*.

Хугацааны эпох болон теоригийн зонхилох байршлаас хамаараад төрийн теоригийн актиорууд дараахи хэлбэрээр илрэх боломжтой.

- Суверен буюу хязгаар үгүй ноёрхогч
- Төр өөрөө абстракт биетээр
- Төрийн ард иргэд
- Дан ганц хүн
- Социалын давхарга
- Үйлдэгч эдийн засгийн субъектүүдийн нийлбэр

Төрийн теори маш олон департерын поинтуудаас гарах боломжтой. Дүрслэдэг, легитимацладаг эсвэл шүүмжлэдэг түүхийн одоо байгаа төрийн системүүдээс, политикийн замбараагийн теоригийн идеалаас тухайлбал төрийн утоп, мөн экономийн эсвэл политик-социалын хүчний структууруудаас, этикийн идейнээс, үүнээс салбарлах хүний зөвүүд ба мэдэлийн ангилал⁴ мэтчилэн. Урьдаас олгогдсон, бурханлаг ч бай, натурын хуулийн эсвэл гэрээний дагуу тохиролцсон замбараа.

Натурын төлөв

Анхлах гол цэг бол төр бүрэлдээгүй эрин үеийн натурын төлвийг тодорхойлох явдал. Английн эртний эрин үеийн философич, төрийн теоретикч Томас Хоббс нийгмийн

⁴ Үүнд демократын гол 3 багана болох *executive, judicative, legislative power* хамрагдана.

гэрээг өөрийн зохиол “Левиатан” -нд бүгд бүгдийн эсрэгийн тэмцлийн (*лат.: bellum omnium contra omnes*) натурын төлвөөс тусгадаг.

Цаад шалтгаан Англи, Шотланд хоорондын иргэний дайнаас буюу парламентын ба хаант засаглалын зөрчилдөөнөөс үүдэлтэй. Энэ натурын төлөвт өрсөлдөөн, үл итгэлцэл ноёрхоно. Ийм үед хүмүүс ямар ч бүтээмж үгүй. Энэ бий болох натурын төлвөөс гарахын тулд хүний ухамсар илүү их натурын хуулиудыг хөгжүүлдэг. Ухамсраас үүдээд хүн бүрийн хүн бүртэйгээ байгуулах сайн дурын гэрээ бий болно. Гэрээнд тулгуурлаад бүгд өөрийн чөлөөг хязгаарлах ба тодорхой эрхийг суверенд даатгана. Ингэснээр тэд төрд хязгаарлагдахгүй хүчийн монополийг гаднаас ба дотроос хүч хэрэглэх халдлагаас хамгаалуулах үүрэгтэй. Гагцхүү суверен өөрөө хүмүүстэй гэрээ байгуулсан биш. Гэрээний бүтэц зөвийн үүднээс тэмдэглэгдсэн бус, харин дарангуйлалын ба абсолют.

Төрийн удирдлагад гарагсад замбарааг үүсгэх үүрэгтэй. Тэд ард иргэдийнхээ эрхшээлээр аюул үгүйг хангах зорилготойгоор бий бологсод. Хэрвээ Руссо радикал демократын төрийн теоригийн байр суурийг төлөөлдөг бол Жон Локк натурын төлвийг чөлөөт болон тэнцүү зөвийн тухай хүний натурын талаас үзнэ. Руссогийн хүн бүр гэрээнд хамрагдаж хамтралыг байгуулах ба үүгээрээ тэд ивээлд автана гэх нийгмийн форм “Левиатан” -ыг бичигч Томас Хоббсынхоос багагүй ялгаатай. Үүгээр Руссо төрийн идеалд хамгийн илүүтэй дөхөхүйц нь олонхийн принцип гэж үзнэ.

Тэгвэл Хоббсын хувьд хүн бүр хууль ба төрд натураасаа баригдалгүй амьдарсан. Натурын төлөвт хэн ч хэнийгээ үл ойшоох ба бүгд бүгдийнхээ эсрэг тэмцэлдэх ертөнцийг үзэх сөрөг зураглалтай. Тэд хэнийг ч хайхралгүй эм ч бай, хүүхэд ч бай хүч хэрэглэхээс зайлсхийсэнгүй. Натурын хуулийн формоор моралийг мэдэх авч өөрийг хамгаалах албадлагаар хайхралгүй орхино. Энэ тэмцэлд хүн үргэлжийн айдас ба аймшигт үхлийн заналхийлэх аюулт, туйлын ганцаардмал, айсан, адгуусын бас богинохон амьдралаар амьдардаг. Хоббсын хувьд хүн амиа бодсон эгоист, социал биш бас хүсэхийн чөлөөг агуулсан байдаггүй.

Натураас бид энэ амьдралд зориулагдаж бүтээгдээгүй, хүн амьдралыг өөрийнхөөрөө бүтээдэг. Амьдралын хэрэгцээгээр бүх хүн бүгдийн ханамжит, энх хамтран оршихуйг сахиулах эрхээс үүдэлтэйгээр гэрээ байгуулсан. Жон Локк энэ аргументыг олон тооны төрүүд болон хүмүүсийн хамтран амьдрахын формуудад үндэслэн гаргасан. Натурын төлөв бол тэнцүү зөвийн байдал, тиймээс натурын хууль хэний ч амьдрал, эзэмшилд хохирол учруулах ёс үгүйг сургадаг. Зөрчсөн тохиолдолд натурын зүйг сахин шийтгүүлэх ёстой, ингэснээр хүн бүрийн тэнцүү зөвийг хангах хийгээд зүйг сахиулах боломжтой. Хоббсын хүнийг үзэх үзэл примитив бол Локкын хувьд интелгенцтэй болоод зогсохгүй *эксекутив* болон *юдикатив* хүчийг байгуулна. Легитимчлэгдсэн засаглал үгүй ч Локкийн натурын төлөв хүний хамтран амьдрахуйгаар бүтээгдсэн.

Руссогийн хувьд хүн бүр натураас тэнцүү бөгөөд автоном, хэн ч төрөхдөө сайн эсвэл муу гэгдэх үндэслэл үгүй ба тэд гагцхүү өөрсдөө зөвт, зөвт биш байдалыг ялгах ёстой. Натурын төлвөөс хүн хувийн өмчийг өөрийн ба бусдын гэж ялгахгүйтэй адил үүний ялгааг ч олохгүй. Натурын төлөвт тэрбээр хүний авъяасын хөгжлийг олж харахгүй, тиймээс хэрэв хүн натурын төлвөөс гарахгүй бол интелгенц цааш төлөвших боломж үгүй ба ямагт хүүхдээрээ үлдэх аюул бий. Натураас үүсэх гачигдлыг давахын тулд хамтран амьдрахын формыг бий болгох чухал. Руссогийн гол зорилго бол натурын төлөвт хүн хүнтэйгээ байгуулах бүх нийгмийн гэрээ. Гэрээг байгуулснаар хүнд бусдын хамт байгуулцсан гэрээнд тулгуурлах нийгэмд харъяалагдах боломж бүрдэнэ. Нэгдсэнээр бусадтай компромисыг олохын тулд хүн өөрийнхөө чөлөөтийг хязгаарлахад хүрнэ. Энэ дурын чөлөөтөөс татгалзах гэрээний эцсийн зорилго өөрийн чөлөөтийг болон аюул үгүй байдалыг хангах. Нийгэмд хамрагдснаар гишүүн бүр политийн нэг субъект. Субъектуудын нийлбэр ямагт олонхийг дагана. Натурын төлөв бол зөвгүйдэл, тиймээс

этикийн натурын төлөвт хүн этикийн хамтралын биет болохын тулд өөртөө хууль оноодог.

Баяраагийн ГАНХӨЛӨГ

Хугацаа гэж юу вэ? Хэн ч надаас
түүний тухай асуухгүй бол би түүний тухай мэднэ.
Харин асуусан хүнд хариулах гэхээр би мэдэхгүй.

Августин

“Би бодож буй тул би байна”.

Декарт.



Демократ төр судлал



Иозэф Алоис Шумпэтэр /Австри-Америкийн экономич, 1883-1950/

Демократ төр гэж ярихаас өмнө "демократ" гэдэг өөрөө юу, ямар болзлуудыг хангаж, хэрхэн явагдаж, хэн түүнийг хэний төлөө ямар метоодоор яаж хэрэгжүүлэх ёстой вэ гэдгийг анхлаад авч үзэх шаадлагатай.

Демократ гэдэг үг эртний Грекийн “*демос*” болон “*кратос*”, орчуулвал *ард иргэд* ба *засаглал* гэсэн хоёр үгнээс бүрдэх ба “*ард иргэдийн засаглал*” бүхий утга илэрхийлнэ. Анх цөөн тооны иргэд Афины төв талбайд цуглан, төрийнхөө хуулийг батласнаар *демократ* бий болсон гэж судлаачид үздэг. Тэр үед демократ ардуудын цуглаан хэлбэрээр явагддаг байсан бол цаашид өргөжсөөр дэлхийн политикин⁵ томоохон салбар болоод зогсохгүй, хамгийн түгээмэл төрийн систем болж чадсан. Хуманы оршиж буй аль ч демократ нийгэмд тухайн улсын иргэд төрийн засгийн удирдлагыг чөлөөт, нууцлагдмал, бусдын албадлагад үл автан, зүйт сонгууль явуулах тэнцүү зөвтэй. Өөрөөр хэлбэл демократ гэдэг иргэдийн төлөөллөөр бүрдсэн төрийн засгийн тэнцвэрт засаглал. Иймд, албаны тушаал, нийгмийн гарал үл харгалзан хэдэн удаа сонгогдох нь тус улсын хуультай уялдан зуун хувь иргэдийн сонирхлоос гардаг ба үүнд хэрэв хууль зааглахгүй бол аль ч салбарын, ямар ч боловсрол, мэргэлжилтэй хүн нэр дэвших боломжтой.

Аливаа политикин демократ систем өөрийгөө бүрэн демократжсан гэж тодорхойлоход сонгуулийн дараахи шинжүүд агуулагдана. Үүнд:

- Нийтлэг сонгууль явуулах. Хуульд заасан насанд хүрсэн иргэн бүр бусдын нөлөөнд үл автан сонгох ба сонгогдох зөвтэй.
- Тэнцүү зөвт сонгууль явуулах. Сонгуульд оролцож буй иргэн бүр тэнцүү зөвтэй ба тухайн сонгуульд нэг кандидатад санал өгөх зөвтэй.
- Чөлөөт сонгууль. Хэн ч бусдын албадлага, дарамт, шахалтанд үл автан сонгуульд оролцох зөвтэй.
- Нууцлагдмал сонгууль явуулах. Сонгогч бүр өөрийн саналыг бусдад үзүүлэлгүй, дэмжсэн кандидатыг сонгох зөвтэй.

Гагцхүү үүнтэй уялдуулаад демократжсан системийн сөрөг талууд илрэх магадтай. Хүн бүр өөрийн зөвөө эдэлж сонгуульд нэрээ дэвшүүлэхээс зайлсхийн, эцэстээ ганц кандидат “*өрсөлдөж*” зуун хувийн санал авах тохиолдолууд гардаг. Дээрхи иргэдийн

⁵ Монгол хэлэнд хэвшсэн “улс төр” хэмээх ухагдахуун политикин сайэнсын төвшинд бүрэн утгаа илэрхийлж чадахгүй гэх үүднээс тус үгийг политик гэдэг үгээр орлуулсан болно.

оролцоо үгүйгээс бус харин нэг намын ноёрхолд автсан эсвэл тоталитар дэглэмт улсуудад явагддаг. Тухайлбал, демократжсан гэх Хойд Солонгосын ерөнхийлөгчийн сонгуулиар ганц кандидат дэвшигдэн зуун хувийн саналтайгаар буюу нэг ч иргэний түтгэлзэл үгүйгээр сонгогддог. Энэ бас демократ систем мөн гэж үү? Туркменистан зэрэг Төв Азийн зарим оронуудад мөн л ялгаа үгүй... Тиймээс сонгуульд кандидатын тоо хоёр ба түүнээс дээш, өөрөөр хэлбэл ямарваа сонгуульд ялагч ба ялагдагч зайлшгүй.

Сонгуулийн тогтолцооноос гадна демократыг тодорхойлох ондоо шалгуур бол халдашгүй байдал. Үүнд:

- Санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэл, информацын нээлттэй байдал. Иргэн бүр реал информацаар хангагдаж, өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой.
- Цугларах, хуралдах зөв. Аливаа улсын иргэн бүр хориг үгүйгээр хурал, цуглаан зохиох, нам, нийгэмлэг байгуулах зөв хязгаарлагдахгүй.
- Сонгогчид хэнийг сонгож буйг мэдэх үүднээс тухайн кандидатын талаар информацтай байж, төрийн засаг болон нийгмийн амьдралтай холбоотой бүхий л информацд хүрэх боломжуудаар хангагдах.

Ямарваа улсын удирдлага доорхи шинжүүдийг агуулсан тохиолдолд демократ төрийн засгийн тухай ярих боломжтой. Үүнд:

- Хэрвээ тухайн улсын иргэд шууд ба шууд бусаар төр засгаас гаргаж буй шийдвэрүүдэд оролцож чадаж буй тохиолдолд.
- Тухайн улсыг тодорхойлох газар нутагт орших иргэд өөрсдөө гадны нөлөөнд авталгүйгээр улсынхаа дотоод бодлогод нөлөөлж чадаж буй тохиолдолд.
- Аливаа политикин нормууд шийдвэр гаргах референдум буюу иргэдийн төлөөлөлүүдтэй бол.
- Демократыг тодорхойлох сонгодог арга бол хувьсгал гаргалгүйгээр төрийн засгийн удирдлагыг солих боломж.

Түүхэнд демократ улсууд хоорондоо дайтсан удаа үгүй. Демократын суурь бол зөвийн чөлөөт байдал. Зөвийн чөлөөт байдлыг олж чадаагүй улс, төрийн засаг демократ системийг бүрэн утгаар хангах боломж үгүй. Өөрөөр хэлбэл төрийн засгийг удирдаж буй удирдагчид шууд ба шууд бусаар хуулиудыг батлан өөрсдөө түүн дор захирагдах демократын нэг хэлбэр.

Америкийн “Фрийдом хаус” -ын 1999 оны судалгаагаар дэлхийн 192 улсаас 85 нь демократ системд шилжсэн байв. Энэ факт 1900 оны нийт 55 тусгаар улсын нэг нь ч эмэгтэйчүүдийн зөвийг хамгаалсан төгс демократжилт явагдаж чадаагүй байсантай харьцуулвал том ялгаа. Монгол Улс XX зууны сүүлээр элсэх ихэнх зүүн Европ болон Төв Азийн шинэхэн демократуудын нэг.

Иозэф Алоис Шумпэтэр - “Капитализм, социализм ба демократ”

Эхний удиртгал хэсэгт дурдсан демократ системийн ерөнхий ухагдахууныг Иозэф А. Шумпэтэрийн - “Капитализм, социализм ба демократ” хэмээх номтой уялдуулж тус хэсэгт тодотгохыг зорилгоо.

Капитализм ба демократын уялдаа, мөн хоорондын харьцааг эдүгээ хоёр зуун жилийн өмнөөс судлан амжилттай хэрэгжүүлсээр ирсэн. Хэрэв одоогийн баруун Европын орнууд технологийг хөгжүүлэн, улмаар үйлдвэржилт бий болгож, буржуазууд төрсөн

капиталист нийгмийг байгуулаад өнөөг хүрсэн бол Монгол Улсын төрийн засгийн тогтолцоо үүнтэй харицуулбал ерээд оны эхээр капитализмыг алгасан социализмаас демократ руу шилжин орсон. Барууны болон бусад өндөр хөгжилтэй орнуудад үзүүлсэн капитализмын гавъяа их. Капитализм юуг бий болгосон бэ гэхээр үйлдвэржилтийг хөгжүүлээд, өөрсдийн хэрэгцээг хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлож борлуулах зэрэг эдийн засагийн салбарт тууштай нөлөө үзүүлсэн. Энэ шилжилтийн амжилт жижиг, том дамжлага дээр ажиллуулахаас эхлээд иргэдээ ажлын байраар хангах явдал байв. Хүн бүр ажлын байртай болно гэдэг худалдан авах чадвар бий болж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараар хангагдана. Ингэснээр иргэдийн дийлэнх ажлын байртай болж, мөнгөний эргэлт үүсч мөн үйлдвэрлэсэн бараагаа эргэлдүүлэх бололцоотой.

Юун түрүүнд өөрийн хэрэгцээг хангана гэдэг тус улсын гадаад харилцааны салбарт давуу талтай бөгөөд бусдаас хараат бус байдлыг бий болгодог. Өнөөдөр Монгол Улс буцалтгүй тусламж, зээл, төлбөрийн зэрэг санхүүгийн туслалцааг гадаадын хөрөнгө оруулагчдаас авахаас ондоо арга үгүйд хүрдэг. Гэвч үүнийг дагаад тухайн орнуудын Монгол Улсад үзүүлэх нөлөө, политикин дарамт нэмэгдэх сөрөг үр дагавартай. Өнөөдөр цахилгааны болон газрын тосны хэрэгцээ хойд хөршөөс хэт хамааралтай. Барель тосны үнийг цөөхөн хэдэн төгрөгөөр нэмэхэд шатахуунаа дагаад бусад тээвэр, хүнс, үйлчилгээний салбарууд үнээ нэмэх хандлага ажиглагддаг. Шатахуун, цахилгаан хойд хөршөөс хараат бол бусад хүнс, хувцас болон ахуйн бараа Хятадаас импортолдог. Эдийн засгийн хараат байдал цаашлаад политикин нөлөөлөл, хязгаарлалд хүргэх эрсдэлтэй.

